

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 5 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-36
<hr/>	
1.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	5-11
2.Төв, суурин газар, аймаг, нийслэлийн хөрсний бохирдол, нүхэн жорлон, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх Эрүүл мэндийн сайд болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох	11-36

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны 5 дугаар сарын 05-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 05 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Ж.Батсуурь, П.Мөнхтулга;
Чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Д.Ганмаа, С.Замира, Ж.Золжаргал;
Эмнэлгийн чөлөөтэй: Р.Эрдэнэбүрэн;
Тасалсан: Б.Пунсалмаа.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, С.Уянга нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Ж.Галбадрах, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, О.Саранчулуун нар үг хэлэв.

О.Номинчимэг: Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах, суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчилж, тэдний оюуны болон бие бялдарын өсөлт хөгжлийг дэмжих чиглэлээр санал, дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг гишүүдийн саналыг тусгаж баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, гишүүдэд Улсыг Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Ц.Мөнхтуяа, Ч.Ундрэм, О.Саранчулуун, М.Сарнай нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төв, суурин газар, аймаг, нийслэлийн хөрсний бохирдол, нүхэн жорлон, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх Эрүүл мэндийн сайд болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, Усны газрын Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга Д.Сайханжаргал, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал Б.Цацрал, Цаг уур, орчны шинжилгээний газрын Уур амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний хэлтсийн дарга Н.Галцог, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Орчны эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан ахлах шинжээч Д.Ичинхорлоо, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга Л.Баттөр, мөн төвийн Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээний албаны дарга А.Энхжаргал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга Б.Мөнхгэрэл, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын газрын дарга Ч.Гүнждагва, Хотын ногоон байгууламжийн хэлтсийн дарга С.Эрдэнэсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, С.Уянга нар байлцав.

Төв, суурин газар, аймаг, нийслэлийн хөрсний бохирдол, нүхэн жорлон, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Сайдын мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Ө.Шижир, Ч.Ундрэм, Ц.Мөнхтуяа, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын газрын дарга Ч.Гүнждагва нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, П.Сайнзориг нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Төв суурин газар, аймаг, нийслэлийн хөрсний бохирдол, нүхэн жорлон түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл сонсов.

Уг асуудлыг 13 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

Мягмар гараг Төрийн ордон “Жанжн Д.Сүхбаатар” танхим 11 цаг 05 минут

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: 2026 оны хаврын ээлжит чуулганы Өргөдлийн байнгын хорооны 5 сарын 5-ны өдрийн хуралдаан нээхэд бэлэн боллоо. Манай ажлын албанаас Байнгын хорооныхоо гишүүдэд зар хүргээд оруулж ирээрэй. Ирц бүртгэх гэж цаг гаруй болж байгаа учраас ирцдээ ороод түр хүлээж байсан гишүүд маань Байнгын хороондоо ирэхийг урьж байна аа.

Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Нийт Байнгын хорооны 21 гишүүнээс 11 гишүүн ирсэн байна. Халтмаагийн Баттулга гишүүн ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Чинбатын Ундрам гишүүн, Хажекбэрийн Жангабыл гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар ирсэн байна.

Өнөөдөр манай Байнгын хорооноос албан ёсоор Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн гадаад томилолттой, бусад ирээгүй гишүүд маань чөлөө хүссэн байна. Тэгээд бас ингээд тойрогтоо ажиллах өөр ажил давхацлаа гэсэн чөлөө хүссэн. Ер нь бол тойрогт ажиллахаа Байнгын хорооны үндсэн үйл ажиллагааныхаа завсар зайгаар хийхгүй бол тэр нь үндсэн ажил болоод Байнгын хороондоо ирэхгүйгээс болоод ирц бүрдэх гэж цаг бас гаруй бусад гишүүдийгээ хүлээлээ. Дараа дараагийн асуудал дээр анхаараад хэрвээ үнэхээр ийм асуудал байвал Байнгын хорооныхон маань хурал эхлэхийн өмнөх өдөр бүгдээрэнгийнх нь ирцийг авдаг энд үнэн бодит мэдээллээ өгч байхгүй бол ийм чирэгдлүүд гарч байна гэдгийг цохон хэлье ээ. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 2 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл батлах байгаа.

Хоёрдугаарт, төв суурин газар, аймаг, нийслэлийн хөрсний бохирдол, нүхэн жорлон, түүнээс шалтгаалсан өвчин, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайд болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсоно оо.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал ажлын хэсэг байгуулах тухай байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Гишүүдээ ирүүлэх үү? Санал хураалттай учраас ажлын албаныхан маань гишүүд рүү хэлээд Байнгын хорооны хуралдаа орохыг урья. Санал хураалттай. Энэ Байнгын хорооны ажлын хэсэг байгуулах тогтоол бол өмнөх бид нарын энэ тулгамдаж байгаа асуудлын мэдээллийг сонсоод энэний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдлийг боловсруулж, бид Улсын Их Хуралд чуулганаар оруулж ЗГ-т үүрэг чиглэл өгөх ийм ажил хийх байгаа. ЕБС-ийн хүүхдүүдийн үдийн хоолны шим тэжээлийг сайжруулах хүртээмжийг сайжруулахтай холбоотой асуудал мөн энэ үдийн хоол гэдэг ЕБС дээр тулгуурласан энэ үдийн хоолны систем бүтэц хүнсий хангалт, ложистик, аюулгүй байдал. Энэ нь нийгэм эдийн засгийн хувьд ямар үр дагавартай юм. Энийг нь зөв болгох энэ асуудал дээр санал, дүгнэлт боловсруулж Улсын Их Хурлын тогтоол боловсруулах ийм ажлын хэсэг бид байгуулахаар өнөөдөр Байнгын хорооны тогтоол оруулж байна аа. Гишүүдээ дуудаад санал хураалт санал асуултаа тэрэн дээрээ яриад яах хүртэл түр микрофоноо хаачихъя.

Эхний хэлэлцэх асуудал.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт туссан хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар мэдээлэл сонсох арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын сайд, ХХААХҮ-ийн сайд, Эрүүл мэндийн сайд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг Байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 1-ний хурлаар хэлэлцсэн.

Үүний үр дүнд Байнгын хорооны гишүүдийн санал, холбогдох мэдээлэл, судалгаанд үндэслэн санал, дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно. Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос тогтоох нь:

1.ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах, сурагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчилж, тэдний оюуны болон бие бялдрын өсөлт хөгжлийг дэмжих чиглэлээр санал, дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай гээд. Энэ дээр ажлын хэсгийн ахлагчаар ажиллая гэж Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн өнөөдөр гадаад томилолттой байгаа. Хүүхэд хамгааллын асуудлаар ажиллаж байгаа. Саналаа ирүүлсэн. Мөн өмнө нь саналаа ирүүлсэн байсан Даваасамбуугийн Ганмаа гишүүн, манай Мөнхтуяа гишүүн, Чинбатын Ундрам гишүүн байна. Өөр саналаараа орох Саранчулуун гишүүн орно тиймээ? Орох уу? Манай Байнгын хороонд Хүнс, хөдөө аж ахуйн сайд Идэрбат гишүүн ирсэн байгаа. Тэгэхээр гол асуудал энэ дээр яригдаж байгаа л асуудал бол шим тэжээлийн хүртээмжтэй шим тэжээлтэй хоолны хүртээмжийн асуудал байгаа. Төсөв мөнгөний асуудал байгаа учраас ядаж 2027 ондоо үе

шаттайгаар энэ хуулийн хэрэгжилтээ хангуулах үүднээс энэ байдлаар нь анхаарч нэг ЗГ-т чиглэл өгсөн тогтоол боловсруулъя гэж байгаа.

Хоёрдугаарт гол нь энэ яг системийг нь зөв хийх, сум орон нутаг, дүүрэг нийслэлийн хэмжээнд энэ хоол хангамжийг яаж зөв хийх вэ гэдэг дээр Хүнс, хөдөө аж ахуйн яамны оролцоо, Боловсролын яамтайгаа хамтарсан ийм байх ёстой. Тэгэхээр энэ дээр тэр асуудлыг нь сайн хэлэлцээд санал, дүгнэлт гаргах асуудлууд байна уу даа гэсэн зүйл өмнөх нөгөө Байнгын хороогоор хэлэлцэгдсэн асуудал дээр харагдаж байсан. Ингээд ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр, холбогдох байгууллага албан тушаалтныг татан оролцуулж ажиллахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Одоогоор ажлын хэсгийн гишүүдээр Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Мөнхтуяа гишүүн, Сарнай гишүүн, Чинбатын Ундррам гишүүд нар байна. Өөр саналтай гишүүд байна уу? Энэ Байнгын хорооны тогтоолын төслийг ингээд та бүхэнд тараасан сая уншиж танилцууллаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Тогтоолын төслийг та бүхэнд тараасан. Санал хэлэх гишүүн Чинбатын Ундррам гишүүнээр тасаллаа. Чинбатын Ундррам гишүүний микрофоныг өгье.

Ч.Ундррам: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид нар маш чухал асуудал дээр ажиллах гэж байгаа. Энэ хүүхдүүдийн үдийн цай хөтөлбөрийг 2020-2024 онд Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд үдийн хоол хөтөлбөр болгож төсвийг тодорхой хэмжээгээр нэмсэн. Тэгээд одоо бид нар энэ хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдал дээр ингээд ажиллах ёстой юм. Тэгэхээр энэ хоолны чанар аюулгүй байдалтай холбоотойгоор энэ үдийн цай, үдийн хоол хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотойгоор ЕБС болон СӨБ-ын байгууллагууд дээр хеликобактерийн тархац нэлээн их байгаа.

Тэгэхээр энэнтэй холбоотой одоо ариун цэврийн асуудал ч юм уу тэр агуулгыг энд нэмж оруулах юм бол нэг мөсөн 1 ажлын хэсгээрээ энэ дээр ажиллачих боломжтой болов уу? Тийм учраас ийм агуулга энэ ажлын хэсгийн энэ зорилго дотор оруулах ийм энэ тогтоолын 1 дүгээр зүйл дээр нэмж оруулах ийм саналтай байна аа. Баярлалаа.

О.Номинчимэг: Ундррам гишүүний ч санал маш чухал. Энэ аюулгүй байдал гэдэг утгаараа энэ чанарын асуудал, хеликобактерийн асуудал, угаалгын асуудал гээд чухал асуудал тавигдаж байгаа учраас энэ агуулгыг тогтоолын 1 дүгээр хэсэгт тусгаж редакцтайгаар цөмөөрөө өнөөдөр батлаад тогтоолын хэсэгт энэ Ундррам гишүүний саналыг тусгая. Энэ юу юм байна лээ. Отгоны Саранчулуун гишүүн санал хэлэх гэж байна. Та бүхэн оруулаарай. Тэр хүртэл ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн үнэлгээ хэрэгжилтийн үнэлгээ гарчихсан. Боловсролын яамнаас захиалаад хийлгэчихсэн юм байна лээ. Би Тамгын газраараа хийлгэх гээд байж байтал хийчихсэн. Тэгээд би албан бичгээр хандаад Боловсролын яамнаас энэ хуулийн хэрэгжилт юун дээрээ доголдоод байна гэдгийг удахгүй өгөөд гишүүддээ өгье гэсэн байгаа. Отгоны Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Бид нар ЕБС-ийн орчинд хоол үйлдвэрлэх үйлчилгээ зэрэг асуудлуудаа харьцангуй яриад хууль боловсруулаад энэнтэй холбоотой ажлууд

явагдаад байгаа. Бид нар юуг орхигдуулчихсан гэхлээр нийгмийн эрүүл мэндийн агуулгаа орхигдуулаад байгаа. Тэнд нь юу байх вэ гэхээр хооллох зан үйл, дадал зуршил, сургуулийн соёлын асуудал, сургуулийн бодлогын асуудлуудыг аль ч сургуулийн бодлого дүрэм журам, хууль дээр уялдаж өгөөгүй. Хоолыг хийчхээд тэр хоолыг идэхтэй холбоотой цагийг нь гаргах, хоол идэхийн өмнө гараа угаах, багш нь өөрөө хоолоо идэх, сургууль өөрөө үдийн хоолоо иддэг ийм соёлтой болох нь өөрөө аягүй ийм чухал хүчин зүйл байгаад байгаа байхгүй юу. Бүүр ийм дадал зуршилтай болгодог.

Тэгэхээр энэ дээр бид нар оруулахын тулд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль чинь өөрөө анхан шатдаа сургууль дээр хэрэгжих ёстой байхгүй юу. Тэр агуулга дээр юу байдаг вэ гэхлээр эрүүл зан үйлийг төлөвшиг төлөвшүүлэх гэдэг агуулга байгаа. Эрүүл дадал зуршил, зан үйл, амьдралын хэв маягийг бид нар хүүхдээ зөв хоол идүүлдэг байлгаж байж эрүүл иргэнтэй болно. Тэгэхээр энэ агуулгыг тусгах хүсэл саналтай байна. Тэгэх юм бол энэ зөвхөн бид нар нэг гал тогоотой хэчнээн сайн гал тогоонд хэчнээн сайн амттай хоол хийгээд бид нар хоолыг зөв хооллох тэр орчин нөхцөл соёлыг нь дэмжиж өгөхгүйгээр тэр эрүүл дадал зуршил бий болохгүй байхгүй юу. Тэгэхээр энэ дээр нэг Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуультай холбодог юм уу эсвэл эрүүл дадал зуршил гэдэгтээ оруулах юм бол энэ арай утга төгөлдөр болох гээд байгаа юм. Яагаад гэвэл одоо энэ дээр харахаар сурагч өөрөө сурагч болон тэдний гэр бүлийн хувьд идэвхгүй зөвхөн сургуулийн зүгээс хийх акшныг харуулсан ажил харагдаад байна л даа. Би болохоор сургууль өөрөө идэвхтэй үйлдэл хийгээд эцэг эхчүүд болон багш сурагчдыг идэвхжүүлэхтэй холбоотой агуулгыг буюу зан үйлтэй холбоотой хэсгийг л нэммээр байгаа гэсэн үг. Найруулгын хувьд мөн хамрах хүрээний хувьд тэгж нэмэх саналтай байна.

О.Номинчимэг: Ажлын албан дээр энэ агуулгыг тэгвэл эвтэйхэн томьёолоод орох асуудал дээр анхааръя. Ер нь яах вэ ийм байгаа Саранчулуун гишүүнд нөгөө бид нар мэдээлэл сонсож байхад одоо жишээ нь Өмнөговь аймаг, Орхон аймаг эд нар болохоор өөрийн төсөв, санхүүгийн байдал, орлого олдог аймгууд байгаа учраас өөрсдийнхөө орон нутгийнхаа төсвөөр 12 дугаар анги хүртэл бүх ангийнхандаа үдийн хоол өгдөг болсон юм байна лээ. Гэнэт 5 хүртэл байсныг нь 12 тэгсэн чинь нөгөө сургуульд байгаа багш нараас гадна сургуулийн ажилтны тоо нь маш их олон болчихсон. Тэгээд нэг ийм хоол үйлдвэрлэлээ гээд тойрсон маш их ачаалал үүсээд нөгөө анги танхим нь яах вэ хоол хэдэн ээлжээр яах вэ гээд тэнд маш их цаг гарч нөгөө үндсэн үйл ажиллагаа гэхээсээ тийшээ их тулгамдаж байна гэсэн санал хүсэлтүүд ирж байгаа юм.

Тэгэхээр бид нар нөгөө яг хоол танхимыг яаж зөв зохион байгуулах вэ энээ тэрээ гэдэг юмыг үе шат дараатайгаар хийхгүй бол одоо зүгээр 1-ээс 5 дугаар ангийнханд л хоол өгч байгаа шүү дээ. Тэгээд шууд 1-ээс 12 гээд өгчих юм блд үнэхээр төсвийн хувьд ч гэсэн анги танхим гал тогооны багтаамжийн хувьд ч гэсэн огцомдоод хэрэгжихэд аягүй хэцүү. Тэгэхээр үе шаттайгаар энийг хэрэгжүүлж ингэж явна. Ингэхэд таны хэлж байгаа тэр хүүхдийн хоол идэх зан үйл орчинд нь яаж тэгвэл нөлөөлөх вэ гэдэг энэ асуудлыг яаж тусих вэ гэдгийг та бүхэн маань ажлын хэсэг дээрээ ярилцаад оруулаад ирэхэд боломжтой байх гэж бодож байна.

Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Би зүгээр ганц юм нэмж хэлье. Манай Анагаахын сургууль дээр ингээд завсарлагааны их завсарлагааны цаг 20 минут байдаг байсан байхгүй

юу. Тэгээд 20 минутад бид нар бүгдээрээ завсарлаж үдийн хоолоо идэж чаддаггүй ийм байсан. Нэг ангиас нөгөө анги руу гүйх хооронд нөгөө цаг нь өнгөрчихдөг байсан. Тэгээд багш нар юу гэж шийдсэн бэ гэхээр их завсарлагааныхаа цагийг 40 минут болгож сунгаснаараа ажлын байрны сэтгэл ханамж болон ажил дээрээ хоол ундаа хийдэг цаг зав илүү гараад дээрээс нь оюутнуудын хувьд ч гэсэн үдийн цайны хамрагдалт нь илүү сайжирсан. Тэгэхээр энэ бол ингээд сургуулийн өөрийн менежментийн асуудал учраас нэг иймэрхүү зөөлөн хүчин зүйл гэх юм уу даа иймэрхүү зүйлүүдийг нь бид нар хамтдаа энэ ажлын хэсгийнхээ хүрээнд ярилцаад явбал болох болов уу гэсэн нэг ийм санал цаана нь байгаа шүү. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Жанчивын Галбадрах гишүүн санал хэлье гэж байна. Жанчивын Галбадрах гишүүний микрофоныг өгье.

Ж.Галбадрах: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Байнгын хорооны даргадаа өглөөний мэнд. Бид үдийн цайнаасаа үдийн хоол руу шилжсэн. Тэгэхээр үдийн хоол гэдэг бол үдийн цай байх үед нэг ундаа, печень зэрэг зүйлээр аргалаад байсан бол одоо үдийн хоол халуун хоол үйлдвэрлэх гэдэг энэ зүйл рүү орсон. Тэгээд энд бэлтгэл маань хэр хангагдсан байгаа юм бол оо. Энэ сургуулиудын тооцоог яг гал зуухтай зарчмын хувьд тэр хоол үйлдвэрлэлээ хийчих тийм гал тогооны тоног хэрэгсэлтэй сургууль хэр байгаа юм. Гал тогоо гэж нэг өрөө байсан байдаг. Сургууль болгонд байгаа. Тэр нь тэгээд бүүр сүүлдээ анги болчихсон ч газар байж байгаа. Зарим нь бүүр төсөл хөтөлбөрөөр маш гоё ийм тоног төхөөрөмжтэй болчихсон байж байдаг. Зарим нь бол зүгээр л нэг гэрийн юу шиг ингээд байж байдаг л даа. Тэгээд ингээд сургууль болгон дээр очихоор тэр үйлдвэрлэл нь өөр өөр, сав суулга нь тэр тараалт нь сая Ундрам гишүүн хэлсэн тэр эрүүл ахуйн нөхцөл байдал ямар ч стандарт байхгүй байгаа.

Тэгэхээр манай энэ ажлын хэсгийнхэн энэ стандартыг тогтоох, тэгээд тэр судалгаагаа хийгээд тэр дутуу гал тогоо нь дутуу газруудыг гаргах. Өнөөдөр яг үйл ажиллагаа явуулж байгаа нь 2 төрлөөр явагдаад байна. Сургууль өөрөө бие дааж тогооч нар авч ажиллуулаад үйл ажиллагаагаа явуулаад нөгөө өдрийн хоолноос орж ирсэн мөнгөөрөө менежментээ хийгээд явж байна. Зарим нь түрээслүүлж байна. Тэгэхээр энэ түрээслүүлж байгаа нь хэчнээн хувьтай байдаг юм бол? Гаднын хүмүүст түрээслүүлчихдэг. Тэгээд нөгөөдүүл нь болохоор одоо бас ашгаа бодож байгаа. Сургууль ч гэсэн хийгээд ингэдэг. Тэгээд нөгөө нэг хүүхдийн 2500 төгрөгийн маань яг хэдэн хувь нь үнэхээр хоолондоо очоод байна хэдэн хувь нь бусад зардалдаа ороод байна гэсэн ийм судалгаа энэ тэр манай ажлын хэсэг л хийх байх л даа. Гарч ирснийх нь дараа ийм зүйлүүдийг хийе. Тэгээд үнэхээр бас хэлж л гишүүд их ярьсан. Би ингээд сургуулиуд дээр очихоор хоол өгөх гэдэг ажил бол сургалтад маш их нөлөөлөөд завгүй болоод ачаалал өгөөд хоолоо тараана гэдэг асуудал тэгээд хүүхдүүд гэр гэрээс аяга тавагний асуудал гэхэд цүнхэн дотор зарим нь том аяга аваад ирнэ. Жижигхэн аяга аваад ирнэ. Тэгээд л энэ асуудлууд гараад байгаа бол аяга таваг халбаганы асуудлыг хүртэл бид нар цаанаас нь ингээд цэгцлэх тэрний тэр угаах тоног төхөөрөмж гэдэг энэ талуудыг манайхан ингээд анхаарах ёстой юм байна гэсэн ийм юм байж байгаа.

Тэгээд түүнээс гадна манай ажлын хэсэг нэг судалгаа хийвэл байгуулагдаж байгаа учраас би хэлээд байгаа юм. Тэгээд энэ дундын хоол зөөдөг нөгөө обенто гэж байдаг. Ссавлачихсан хоолны хэлбэрээр нь ингээд үйлдвэрлээд тэгээд ойрхон ойрхон газруудад ингэж явуулдаг тоног төхөөрөмжөөр очвол тэр ингээд савтай хоолыг тараахад бол цаг нэг их ордоггүй. Тэгээд сая Саранчулуун гишүүний

хэлсэнчлэн тэр цагийг менежмент хийгээд нэг 20 минут ч юм уу гаргая л даа. Тэгээд 20 минут нь гаргахдаа өглөөний 9 цагаас тэгээд энэ бол сургуулийн дотоод менежментийн асуудал. Тэгтэл ямар ч байсан хүүхдүүдийгээ бөөгнөрч ингэж явахгүй тийм байдлаар хийх талын судалгаануудыг хийвэл зүйтэй байна л гэсэн ийм санал хэлье. Тэгээд зарим ер нь гал зуухны судалгаа байгаа бол...

О.Номинчимэг: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн санал хэлэх гэж байна? Галбадрах гишүүний асуултад ерөнхийдөө мэдээлэл өгөхөд бид нар өмнө нь нөгөө 4 сарын 1-нд Боловсролын яамнаас мэдээлэл сонсоход бол энэ судалгаанууд бүгд бэлэн байгаа юм байна лээ. Ялангуяа хөдөө орон нутаг харьцангуй гайгүй хотод нийслэл хотод байгаа сургуулиуд дээр гал тогооны асуудал хүртээмжгүй байгаатай холбоотой тоо баримтууд гарсан. Тэгээд үе шаттайгаар энийгээ шийдэж байгаа. Энэ хэрэгтэй төсөв мөнгөний асуудал хүртээмжийг сайжруулах асуудал гээд энэ тоо тооцоонууд нь байгаа. Манай ажлын хэсэг эд нарыг аваад тэгвэл цаашид ямар үйл ажиллагаа арга хэмжээ авах вэ гэдэг дээр өөрсдийнхөө санал, дүгнэлтийг гаргаж ажиллах байх гэж бодож байна.

Тэгээд үдийн хоол гэдэг маань бүхэл бүтэн бүүр ийм том судлагдахуун болсон дэлхийд асуудал юм байна лээ. Тэр бэлэн хоол тараах юм уу эсвэл сургууль дээрээ халуун яг чигээр нь хүүхдүүддээ өгөх нь тэр шим тэжээлд яаж нөлөөлдөг вэ гэх мэтчилэн нарийн юмнууд байгаа учраас манай энэ асуудал дээр маш их анхаарч байгаа. Гишүүд маань энэ тал дээр бас сайн ажлын хэсэг дээрээ яриад Байнгын хороондоо танилцуулаад Улсын Их Хурал руу энэ тогтоолын төслөө шийдвэрүүдээ оруулъя гэж бодож байгаа.

Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ер нь бол энэ хүүхдийн үдийн хоолны асуудал дээр хүүхдийн хоолоор бизнес хийдэг мафи мафийн сүлжээний асуудал хөндөгддөггүй. Хэдхэн тооны компаниуд монополдож хүүхдийн хоол нийлүүлдэг. Тэр нийлүүлж байгаа нь зах зээлийн үнээс маш өндөр үнэтэй. Тэгээд чанаргүй. Энэ асуудлыг бол сургуулийн захирлууд над руу маш их мэдээлэл ирдэг ээ. Энийг бүүр Энх-Амгалан сайдтай хамтраад ажил болгоё, юун сая энэ ажлын хэсэгт орчихлоо. Тэгээд энэ ажлын хэсгээрээ дамжуулаад энэ хүүхдийн ам руу орж байгаа, ходоод руу орж байгаа энэ хоолны чанарын асуудал дээр бид нар тэр нөгөө мафийн сүлжээтэй тэмцэхээс эхлэх байх гэж бодож байна. Сургуулийн орчинд бол мэдээж хөөрхий тэр тогооч нар бүхий л сэтгэл зүрх бүх юмаа зориулж хүүхдэд хоол хийж байгаа шүү дээ байгаа материалаар нь.

Гэтэл энэ нөгөө хоолны нөгөө бүтээгдэхүүн нийлүүлж байгаа бүтээгдэхүүн ямар ирж байна. Нэг тоотой хэдхэн компаниас ав гээд ингээд дээрээсээ дарамталдаг, тендер зарладаг. Энэ асуудлыг таслан зогсоомоор байна гэж бодож байна 1 дүгээрт.

Хоёрдугаарт нь энэ үдийн цай аравхан минутаг өгдөг өө. 40, 50 хүүхэд шаагаад ингээд ангийнх нь багш аягалаад ингээд хичээл орсон ч биш ороогүй ч биш ийм замбараагүй байдал үүсдэг. Би өөрөө ингээд бага ангийн багш хийж байсан хүн болохоор энийг аягүй сайн мэдэж байгаа. Тийм учраас энэн дээр сая Саранчулуун гишүүн ч гэсэн санал оруулж байна. Үдийн цайны цагийг нэмэх хэрэгтэй. Дээрээс нь тэр нөгөө түгээлтийн хоол нь бараг илүү үр дүнтэй дээ. Нөгөө чанар дээр нь анхаарчихвал. Багш аягалаад явахаар л аягүй хэцүү болчихдог байхгүй юу. Хичээлээ заах уу, хоолоо аягалах уу ийм асуудал байна.

О.Номинчимэг: Баярлалаа. Тэгэхээр гишүүд маань санал хэллээ. Ялангуяа тэр тогтоолын агуулгад оруулах Ундрам гишүүн, Саранчулуун гишүүний хэлсэн асуудлуудыг тусгасан байдлаар тэгэхээр цөмөөрөө тогтоолынхоо төсөлд нэмээд санал хураалтаа явуулъя гэж бодож байна. Гишүүд асуулт асууж саналаа хэлж дууслаа. Ингээд санал хураалтад бэлдье ээ.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг сая хэлсэн Чинбатын Ундрам гишүүн, Отгоны Саранчулуун гишүүдийн хэлсэн агуулгыг тусгасан байдлаар баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 11 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 54.5 хувиар Байнгын хорооны тогтоолын төсөл дэмжигдлээ.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

11.33 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёрдугаар асуудал.

Төв суурин газар, аймаг нийслэлийн хөрсний бохирдол, нүхэн жорлон, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайд болон Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайдын мэдээлэл

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг арай ирээгүй байна. Ажлын хэсгийг оруулъя 2 дахь асуудал.

Өнөөдөр энд хэлэлцэх гэж байгаа төв суурин газрын хөрсний бохирдол, нүхэн жорлон, түүнээс шалтгаалж байгаа өвчлөл урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар энэ холбогдох хуулийн хэрэгжилттэй танилцаж хяналт хийх цаглавар манай Байнгын хорооны цаглаварт туссан байгаа. Отгоны Саранчулуун гишүүний санаачилгаар. Одоо урин цаг ирж байна. Бид нар улирлын шинж чанартай яг энэ үед ирэхээр л энэ хөрсний бохирдол маань яаж байна ийж байна бид нар юу хийж байна гэдгээ нэг ярьдаг.

Уг нь бол энийг байнга жилийн 4 улиралтай яриад, арга хэмжээгээ аваад, тодорхой дунд, урт хугацааныхаа зүйлүүдийг төлөвлөж явах нь зүйтэй байгаа. Тэгээд өнөөдөр Байнгын хорооны түвшинд цаглаварын дагуу энэ асуудлыг мэдээллийг сонсож цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэхээр орсон байгаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг эхлээд танилцуулах юм байна. Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД Ш.Батбаяр ирсэн байна. Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого үнэлгээний газрын дарга Энхмөнх ирсэн байна. Усны газар удирдлага санхүүгийн хэлтсийн дарга Сайханжаргал ирсэн байна. Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн захирал Цацрал ирсэн байна. Цаг уур орчны шинжилгээний газрын уурь амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний хэлтсийн дарга Галцог ирсэн байна.

Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр ирсэн байна. ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Цэцэгсайхан ирсэн байна. ЭМЯ-ны Орчны эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан ахлах шинжээч Ичинхорлоо ирсэн байна. НЭМҮТ-ийн Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээний албаны дарга Энхжаргал ирсэн байна. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын газрын дарга Гүнждагва ирсэн байна. Хотын ногоон байгууламжийн хэлтсийн дарга Эрдэнэсайхан. Нийслэлийн 2 яасан. Энд ирсэн гэж тэмдэглэсэн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны 2-ыг дуудаарай. Ажлын хэсэгт орж ирж байна уу? Ирсэн гэж энэ тэмдэглэгээн дээр байх юм. Ингээд өнөөдөр 2 яамны сайдын танилцуулгыг эхлээд сонсоно. Эхлээд Эрүүл мэндийн яамны ТНБД Эрдэнэбаяр энэ асуудалтай холбоотой хөрсний бохирдол түүнээс үүдэж байгаа өвчлөл урьдчилан сэргийлэх ажиллагааны талаар мэдээллээ танилцуулна уу? Эрдэнэбаяр дарга 5 номерын микрофон нээе. 10 минутаар юу ч гэсэн нээгээдэхье.

Н.Эрдэнэбаяр: Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Төв суурин газрын хөрсний бохирдлын өнөөгийн нөхцөл байдал, нүхэн жорлон, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар товч танилцуулж байна. Төрийн хянан шалгах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймаг нийслэлийн суурьшлын бүсийн хөрсний бохирдлын түвшнийг үнэлэн холбогдох стандартын хэрэгжилтийг шалгаж үнэлгээ дүгнэлт өгөх зорилгоор Эрүүл мэндийн яамны салбарын ХШҮДАГ-аас хот суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулан ажиллаж байна. 2023-2025 онд нийт 601 хөрсний дээжийг шинжилсэн ба шинжилгээний дүнгээс харахад 48 хувь нь цэвэр, 25 хувь нь бага, 18.8 хувь нь дунд, 7.8 хувь нь их бохирдолтой гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа. 2025 онд хийсэн хөрсний бохирдлын түвшнийг тодорхойлох нян судлалын шинжилгээг 2024 онтой харьцуулахад их бохирдолтой ангилалд хамаарах дээжийн эзлэх хувь 0.4 хуваарилалт буюу үл мэдэг буурч, дунд зэргийн бохирдолтой ангилалд хамаарах дээжийн тоо 8.18 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна аа. Энэ нь гэр хорооллын бүсэд төвлөрсөн ариун цэврийн байгууламж, бохир усны шугам сүлжээний асуудлыг цогцоор нь шийдвэрлээгүй нөхцөлд хөрсний бохирдлыг тууштай бууруулж чадахгүй болохыг харуулж байна.

2023-2025 онд хийсэн хөрсний химийн шинжилгээний үзүүлэлтээр 345 дээжийн 9.8 хувьд нь нитратын агууламж, 13.04 хувьд нь сульфатын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр агууламжтай гарч байгаа нь хүн амын төвлөрөл ихтэй худалдаа үйлчилгээний төв зах орчмын бүсэд бохирдуулагч эх үүсвэрүүдийн асуудлыг хойшлуулшгүй шийдвэрлэх шаардлагатай байгааг харуулж байна аа.

Улсын хэмжээнд орчны лабораторийн чадавх хангалтгүй аймгуудын стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораториудын дийлэнх нь чанарын хяналтын итгэмжлэлгүй урвалж бодисын хүртээмж муу, химийн шинжилгээний бүрэн багц хийх боломжгүй нөхцөл байдал хэвээр байгаа нь улсын хэмжээнд хөрсний бохирдлыг бодит байдлыг бүрэн үнэлэх, эрсдэлийн бодлогын түвшинд удирдах боломжийг хязгаарлаж байна. 2025 онд Алтангэрэл нарын судалгаагаар

Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн 93.5 хувь нь шаардлага хангаагүй нүхэн жорлонг ашиглаж байна аа. Тэдгээрийн 58.6 хувь нь угаадасны нүх нь тусдаа биш бохир ус шууд хөрсөнд шингэх нөхцөлийг бүрдүүлсэн байгаа. Энэ мөн 75 гаруй хувь нь шавжийн бохирдол ихтэй, 80 гаруй хувь нь жорлонгоо шинэчлэх шаардлагатай гэж ийм дүгнэлт гарсан байгаа. Энэ нь хөрсөөр дамжих халдварын эрсдэлийг нэмэгдүүлж ялангуяа бага насны хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэсэн ийм дүгнэлтийг гаргасан байна.

Сүүлийн 10 жилийн дунджаар манай улсад 6900 гаруй гэдэсний халдварт өвчин бүртгэгдэж байсан бол энэ нийт 10 мянган хүн амд гэдэг бол олон улсынхаа тооцооллоор бол 21.8 тохиолдол ингэж ноогдож байгаа. 2024 онд 7463 тохиолдол бүртгэгдсэн нь 2023 ондтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа. Нийт халдварын өвчний 20 орчим хувийг гэдэсний халдвар эзэлж байгаа бөгөөд цусан суулга, гар, хөл, амны өвчин зонхилж байна аа. Монгол Улс орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг 2005 оноос хойш 3 дахь удаагаа батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх орчны эрсдэлт хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг бууруулахад анхааран ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд болон 2025-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилтыг тусган салбар хоорондын уялдаа холбоог ханган үе шаттай хэрэгжүүлж ажиллаж байна. 2023 онд ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн сангийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хамтарсан хяналтын хөтөлбөрөөс гаргасан аргачлалын дагуу улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 319 эрүүл мэндийн байгууллагын ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй, хог хаягдлын менежмент, орчны цэвэрлэгээний үнэлгээний түвшнийг тус тус үнэлсэн байгаа. Энэ үнэлгээгээр эрүүл мэндийн байгууллагын 76.2 нь буюу 243 байгууллага нь аймаг, нийслэл, сумын нэгдсэн ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон бөгөөд энэ үзүүлэлт нь хот хөдөөд ихээхэн ялгаатай буюу нийслэлд 88.5 хувь аймгийн төвд 86.2 хувь байгаа, сумын төвд 31.3 хувьтай л байгаа.

Харин 14.1 хувь нь буюу 45 байгууллага бохирын цооногт холбогдсон эмнэлэг дотроо байрласан усаар зайлуулдаг жорлон 9.4 хувь нь буюу 30 байгууллага нүхэн жорлонг тус тус ашиглаж байгаа ийм үнэлгээ гарсан байна. Аймаг орон нутагт эрүүл мэндийн байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх, сайжруулах, ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж болзошгүй эрсдэлд бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Түүнчлэн олон нийтэд чиглэсэн сургалт мэдээлэл нөлөөллийн ажлыг зохион байгуулж эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг төлөвшүүлэхэд анхааран ажиллаж байна аа.

Хөрсний бохирдлын гол шалтгаан нь нүхэн жорлон, бохир усны зохицуулалтгүй байдал бөгөөд энэ нь хүн амын эрүүл мэнд гэдэсний халдварт өвчлөлд нөлөөлж байгаа. Иймд бид цаашид гэр хорооллын ариун цэврийн дэд бүтцийг үе шаттай шийдвэрлэх, нүхэн жорлонгийн стандартыг шинэчлэх, хөрсний бохирдлын эх үүсвэрийг бууруулах, лабораторийн чадавхыг бэхжүүлэх, салбар хоорондын уялдаа хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэсэн ийм цаашдын зорилтыг дэвшүүлж ингэж ажиллаж байна.

Ингээд товч танилцуулга үгээр өндөрлөж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

О.Номинчимэг: Эрдэнэбаяр ТНБД-д баярлалаа. Дараагийн мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД Батбаяр танилцуулна. Яамдуудаа сайд нараас ирүүлсэн мэдээллийг өмнө нь Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн байгаа. Манай Байнгын хорооны гишүүн биш гишүүд ирсэн байгаа учраас тэр мэдээллийг гишүүдэд өгөөрэй. Батбаяр дарга 8 номер уу? 8 номерын микрофоныг нээе.

Ш.Батбаяр: Эрхэм хүндэт Өргөдлийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Төв суурин газар, аймаг, нийслэлийн хөрсний бохирдлын талаарх мэдээллийг, товч танилцуулгыг хүргэе ээ.

Монгол Улсын хувьд хөрсний бохирдол нь гэр хорооллын нүхэн жорлон, хог хаягдал боловсруулах үйлдвэрүүд, уул уурхай, тээврийн хэрэгсэл зэргээс шалтгаалан ихсэж байна аа. Хүн ам өсөхийн хэрээр хүний хэрэглээ тасралтгүй өсөхийн сацуу хөдөөгөөс хот суурин газар руу шилжих хөдөлгөөн нэмэгдэж байгальд хаягдах хог хаягдал болон орчны бохирдол нэмэгдсээр байна аа.

Тухайлбал улсын хэмжээнд энгийн хог хаягдлын хэмжээ 2024 онд 2.6 сая тонн байсан бол мөн өмнөх оныхоос 1.9 хувь буюу 48.2 мянган тонноор нэмэгдсэн байна аа. Улсын хэмжээнд нийт хог хаягдлын хэмжээний 77.2 хувийг Улаанбаатар хотод, 87.3 хувийг ландфил аргаар боловсруулж устгаж байна. ЦУОШГ-аас орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрсний чанарын хяналт шинжилгээг Улаанбаатар хотод жил бүр 107 хүртэл цэгт аймгийн төвүүдэд 2 жил тутам 400 цэгт улсын хэмжээнд зохион байгуулдаг. 2016 онд нийт 8 цэгт хромын бохирдол стандартаас давсан үзүүлэлттэй байснаас нэг цэгт стандартаас 4 дахин их буюу аюултай агууламжид хүрч бохирдсон байна. 2017-2025 онуудад тус бүр 1-ээс 3 цэгт хромын агууламж стандартад зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй гарсан. Стандарт хэмжээнээс давсан цайрын агууламж жил бүр тодорхой цэгүүдэд тогтмол илэрч байсан бол ковальт бохирдсон цэг 2021 оноос хойш гараагүй байна аа. Хөрсний чанарын хяналт шинжилгээний 2024 оны дүнгээр Улаанбаатар хотод 5 цэгт хүнд металлын бохирдол илэрсэн. 2025 онд давхардсан тоогоор 22 цэгт хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээнээс стандартаас давсан бохирдол илэрсэн. ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн нийслэлийн хөрсний нянгийн бохирдолд хийсэн 2021 оны судалгаагаар нийт 76 цэгийн дээжийн 88 хувьд гэр хороолол орчмын хөрсний дээжийн 93 хувьд тодорхой хэмжээгээр нян хөгц мөөг илэрсэн бөгөөд бохирдол дунджаар 6.3 метрт байна гэсэн дүн гарсан. Тус яамны захиалгаар 2024 онд улсын хэмжээнд 1100 мониторингийн цэгийг шинээр тогтоож Улаанбаатар хотын хэмжээнд 333 дээж авч хөрсний нянгийн бохирдлыг шинжлэхэд нийт дээжийн 71 хувьд нянгийн бохирдол илэрсэн бөгөөд бохирдлын зэрэг харилцан адилгүй байна аа. Тухайлбал Улаанбаатар хотын мониторингийн цэгүүдийн 32.3-д гэдэсний савханцар нян илэрсэн бол 70 хувьд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илэрсэн. Хөрсний нянгийн бохирдлын гол эх үүсвэр нь стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлон байна. 2024 оны байдлаар улсын хэмжээнд айл өрх, ААН нийтийн эзэмшлийн стандартын шаардлагад нийцээгүй нийт 495308 нүхэн жорлонтой гэсэн албан ёсны тоо бидэнд байгаа бөгөөд 2025 онд 7 хувь буюу 34826, 2026 онд 15.6 хувь буюу 78093, 2027 онд 20.9 хувь буюу 103361, 2028 онд 49.9 хувь буюу 247446 гэсэн тоо хэмжээгээр нүхэн жорлонгийн тоог бууруулахаар аймаг нийслэлээс төлөвлөгөөг ирүүлсэн. Гэсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 9797 нүхэн жорлонг буулгаж 9626

стандартад нийцсэн жорлонг барьж байгуулаад байна. 2025 онд нүхэн жорлонгийн тоог 34826 ширхгээр буюу 7 хувиар бууруулна гэж төлөвлөсөн ч тухайн дүнгээс 13919 нүхэн жорлонг дутуу бууруулсан нь суурь түвшнээс 4.2 хувиар бууруулсан үзүүлэлттэйтай гарсан. Үүнд төлөвлөлтийн алдаатай баталсан Завхан аймаг тайлан хүрээлэнгүй Ховд аймгийн дүнгүүд өндрөөр нөлөөлсөн байна аа. Жил бүр сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгуулдаг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хамтран ажиллах гэрээнд хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ болон орон нутгийн удирдлагын баталсан нүхэн жорлонг бууруулах 2025-2028 оны төлөвлөгөөг тусгуулдаг бөгөөд 2025 онд гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилт улсын хэмжээнд 63.6 хувьтай байна. Хөрсний бохирдлыг бууруулах цогц арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг яамнаас авч хэрэгжүүлж байна.

Үүнд:

Хууль эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль болон Хог хаягдлын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар үзэл баримтлалыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.

Хоёрт байгаль орчны судалгаа шинжилгээний лабораторийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор хөрсний хүнд металлыг нарийвчлан тодорхойлох ICPOS болон микро долгионы сорьц задлагч багаж тоног төхөөрөмжөөр ЦУОШГ-ын харьяа Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийг хангаад байна. Уг ажилд 800 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс зарцуулсан.

Ногоон зээлийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 оноос эхлэн банкнуудтай гэрээ байгуулж иргэд ААН-ийг хөнгөлөлттэй зээлд хамруулж байна. 2026 оны байдлаар 600 сая төгрөгийг зээлийн хүүгийн татаасын гэрээ байгуулсан банкнуудад олгохоор төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Тус зээлд ариун тээврийн байгууламжтай холбоотой иргэдэд зориулсан 6 хувийн зээлийн 2, ААН-д зориулсан 8 хувийн зээлийн 2 бүтээгдэхүүнийг тус тус оруулсан.

Дөрөвдүгээрт ШУА-ийн Биологийн хүрээлэнтэй хамтран хөрсний бохирдлыг бууруулах 5 жишиг төсөл Газар зүй экологийн хүрээлэнтэй хамтран хөрсний бохирдлыг бууруулах аргачлалыг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Мөн улсын хэмжээнд жил бүр зохион байгуулдаг хөрсний чанарыг хяналт шинжилгээний үр дүнд үндэслэн хөрсний бохирдол ихтэй газруудад бохирдлыг бууруулах, саармагжуулах арга хэмжээг төлөвлөх шат дараатай шийдвэрлэх зорилгоор олон улсын бронфилд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тавдугаарт ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ногоон бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор 2010 оноос эхлэн хэрэгжүүлж буй ногоон технологи үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг бөгөөд энэ онд мөн зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Зургадугаарт Байгаль орчин, уур амьсгалын сайдын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн ШТС-аас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах арга

хэмжээг эрчимжүүлэх тухай 2025 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хөрс бохирдуулагч нүхэн жорлонг шат дараатай буулгах арга хэмжээг эрчимжүүлэх тухай албан даалгавраар холбогдох байгууллагуудад хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг үүрэгжүүлсэн. 2024 оны 07 тоот албан байгууллагын хэрэгжилт улсын хэмжээнд 45 хувьтай, 2025 оны А01 албан даалгаврын хэрэгжилт улсын хэмжээнд 63.6 хувийн биелэлттэй байна.

Долоодугаарт, газар өмчлөх, эзэмших болон ашиглах эрхийг олгохдоо ариун цэврийн байгууламж нүхэн жорлонтой холбоотой стандартуудыг баримталж ажиллах. Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хөрсний бохирдлыг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллах чиглэлийг аймаг нийслэлд хүргүүлээд байна аа.

Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх хүрээнд хүрээлэн буй орчны зөрчлийг мэдээлэх, цахим платформыг хөгжүүлэн ашиглаж байна аа. Цаашид бид хууль тогтоомж болон Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд туссан зорилтуудын хэрэгжилтийг хангуулах энэхүү хурлаас гарсан бодлого шийдвэрийг хэрэгжүүлж хүний хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй орчны бохирдол тэр тусмаа хөрсний бохирдлын талаар иргэд олон нийтийн мэдлэгийг олон нийтэд нэмэгдүүлэх шинжлэх ухаанд суурилсан мэдлэг үр дүнг нэвтрүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллагууд болон бүхий л оролцогч талууд түншлэх байгууллагуудыг дэмжин ажиллах болно оо.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

О.Номинчимэг: Батбаяр Төрийн нарийн бичиг даргад баярлалаа.

Ингээд танилцуулга, мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Отгоны Саранчулуун гишүүнээр 5 гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар эхлээд Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Монгол Улсын ЗГ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт орчны эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх салбар хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагааг бэхжүүлэх гээд тусгачихсан байгаа. Тэгээд 2025-2028 онд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах нь гээд нэг уулзалт хэлэлцүүлэг хийсэн байна. Тэгэхээр би ганцхан л тоо л асууя л даа.

Яг энэ орчны эрүүл мэндийн арга хэмжээний энэ төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх салбар дундын уялдааг хангах хамтын ажиллагаатай холбоотойгоор ямар мөнгө төсөв улсын төсөвт тусгагдсан бэ? Энэ дээр яг тоотой тодруулъя. Тэр мөнгө нь хаана байгаа юм бэ гэдгийг тодруулъя.

Хоёрдугаарт нь Засаг дарга Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль бид нар хуультай тэр хуулийн 10.1 дээр Засаг дарга нарын үүрэг байгаа. Тэр үүрэг нь өөрөө Эрүүл мэндийн сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд жил болгон тусгагддаг. Тэрэн дээр юу гэж тусгадаг вэ гэхээр би та нарт уншиж өгье л дөө. Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж 1-ээс 2 сумын ЭМТ-ийн ариун цэврийн байгууламжийг стандартын

дагуу шинэчлэн байгуулах гэдэг ийм арга хэмжээг тусгана гэсэн байгаа. Одоогийн байдлаар бид нар чинь 21 аймаг 9 дүүргийн асуудлыг ярьж байгаа. Бид нарт ирсэн мэдээллээр Дорнод, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгуудад бол ахиц дэвшил гараад ажиллаж байгаа юм байна гэж ойлголоо.

Бусад аймгууд нь ямар түвшинтэй байна вэ гэдгийг мэдээд тэгээд тодруулъя.

О.Номинчимэг: Эрүүл мэндийн яамнаас асуусан уу? 5 номер, Эрдэнэбаяр дарга.

Н.Эрдэнэбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя аа. Яг энэ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан орчны эрүүл мэнд арга хэмжээ 2025-2028 оны төлөвлөгөө бол Эрүүл мэндийн сайдын 2025 оны 465 дугаар тушаалаар батлагдсан байгаа. Энэ дээр яг төсөв дээр суусан яг энэ орчны эрүүл мэнд гэсэн байдлаар тусгагдсан юу бол байхгүй юм байна лээ. Яг төсөв, яг тухайлсан тавьсан төсөв байхгүй. Энийг Эрүүл мэндийн яаман дээр бид нар ярьж байгаад яасан бэ гэхээр Эрүүл мэндийг дэмжих сангийн 4 төрлийн зориулалтын ийм зардал байгаад байгаа. Энэ дээрээ ерөнхийдөө тусгаад төсвөө баталчихсан байж байгаа. Одоо энийг бид нар яг эрүүл мэндийн дэмжих санг сүүлийн нөгөө энэ хуулиудын өөрчлөлтүүдтэй холбоотой энэ төсвийг нэг дахиж шинэчилж батлахаар ажиллаж байгаа. Тэгээд одоо энэ дээр манай Нийгмийн эрүүл мэндийн газраас саналууд оруулаад ирчихсэн. Энийг бид нар яг бас энэ он дээр ялангуяа энэ дээр хэрэгжилтүүд дээр нь нэлээн анхаарч ажиллая гэдэг ийм асуудал байж байгаа.

Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт дээр та бүхэнд тараасан материал дээр бид нар ингээд ер нь бол өгсөн байж байгаа. Энэ зарим аймгууд маань нэлээн тийм ахиц дэвшил гарч байгаа бол зарим аймгууд дээр бид нар тухайлсан ахицууд их бага байгаад байгаа. Тэгээд энэ жилийн Засаг даргатай байгуулсан гэрээн дээр энэ Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн асуудлууд тусгагдаж өгсөн. Энэний биелэлтийг бид нар хагас бүтэн жилээрээ ингээд аваад ярилцаад явъя энийг ер нь зүгээр эрчимжүүлэх чиглэл дээрээ бид нар нэлээн анхаарал хандуулж ингэж ажиллая гэдэг байдлаар явж байгаа. Ялангуяа энэ сумд дээр энэ нүхэн жорлонгийн асуудал гэдэг юм уу яг энэ шаардлага хангасан стандарт хангасан энэ асуудлууд нэлээн их хүндрэлтэй байгаад байгаа учраас энийг ер нь бид нар 2027 онд эрүүл мэндийг дэмжих жил болж байгаа. Ер нь ингээд 2027 ондоо багтаад ер нь 100 хувь дуусгая гэдэг байдлаар энэ ямар одоо нэг байдлаар 2027 оны төсөв дээр энэ үлдсэн энэ аймаг, сумын энэ эрүүл мэндийн байгууллагуудын байгууламжуудыг төвлөрсөн систем рүү холбох тал дээр нь юм уу эс үгүй бол өшөө сүүлийн үед гарч ирж байгаа энэ дэвшлүүдийг ашиглаад ашиглаад нөгөө стандарттай шинээр туссан тэр цооног ашиглаад гэдэг юм уу ингэж ийм байдлаар явъя гэдэг ийм зүйлийг бид нар яаман дээрээ ярилцаад ингэж ажиллаж байгаа.

О.Номинчимэг: Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Маш энгийн бас нэг зүйлийг Байгаль орчны яамны юм уу эсвэл холбогдох газраас асууя. Улаанбаатар хотод орон нутгаас нүүж ирээд тэгээд өгч байгаа газар дээр хуваарилагдсан газар дээр нүүж ирж байгаа нэг өрх байлаа гэж бодъё. Тэнд газар дээр нь хашаа хатгаад гэрээ барилаа. Тэр хүнд ямар эрх зүйн гэдэг юм уу мэдээллийн нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл очих юм. Жорлонгийнх нь асуудал дээр хаанаас ямар заавар очдог вэ? Байгаа тогтолцоог ямаршуу дүр

зураг харагддаг юм. Хороо халамжийн газрыг бүртгэж авчхаад болчихдог юм уу эсвэл давхар ер нь энэ нийгмийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл заавар өгдөг ийм үйлчилгээ хүрдэг юм уу хүрдэггүй юм уу. Өнөөдрийн байдлаар ер нь манайд энэ зохицуулалт ямар байгаа гэдэг дээр нэг мэдээлэл өгөөч.

О.Номинчимэг: Байгаль орчны яам уу? Тэгээд дараа нь нийслэл Гүнжиддагва дарга нэмээд хариулаарай. 8 номер.

Ш.Батбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя аа.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Нийслэл хотод шинээр нүүж ирээд газар олголтоор газар авч байгаа айл өрхүүдэд бол нийслэлийн холбогдох нэгжүүдээс жорлонгийн асуудлаа шийдэх зөвлөмжийг өгдөг гэж ойлгож байгаа. Манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2023 онд био жорлонгийн 18 арга технологи бүхий аргачлалыг гаргаад нийслэл хотын удирдлагуудад болон орон нутгийн удирдлагуудад хүргүүлсэн байгаа. 18 төрлийн аргачлалаар энэ жорлонгийн нүхэн жорлонгийн асуудлыг шийдвэрлээч гэдэг зөвлөмжийг өгсөн байгаа. Энэ зөвлөмжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвشلүүдэд ногоон зээл олгох ажлыг санхүүжилтийг тодорхой хэмжээний дүнг жил бүрийн улсын төсөвт суурилуулж суулгаж явж байгаа. Хороо нэгжүүдээс иргэдэд өгч байгаа шаардлага зөвлөмжийн биелэлттэй.

О.Номинчимэг: Зөвлөмж нь ингээд 13 арга зүйгээр гарчихдаг юм байна. Энийг хэрэгжүүлэхдээ яаж байна гэдэг дээр нийслэлээс хариулах уу хэдэн номер вэ? 2 уу? Нэг үү?

Захирагчийн ажлын алба 2 номер нэрээ хэлээд хариулаарай.

Ч.Гүнждагва: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Улаанбаатар хотын Захирагчийн албаны Тохижилт, хог хаягдал удирдлагын газрын дарга Гүнждагва. Ерөнхийдөө бол хөдөө орон нутгаас шилжиж ирсэн иргэд шинээр газар авсантай холбоотойгоор НБОГ-аас суурьшлын талаар, болон дахин төлөвлөлтийн талаар мөн нүхэн жорлонтой холбоотой ариутгалтай холбоотой мэдээллийг тухай бүр нь өгч явдаг аа. Энийг дүүргээр дамжуулж өгдөг.

О.Номинчимэг: Яаж өгдөг юм гэж? Нэмэлтээр ямар мэдээллийг ирэхэд нь өгөөд, зааварчилгаа яадаг тэр юуг нь процесс ямар байдлаар өгдөг юм гэдэг мэдээллийг гишүүнээс асуусан байна. 2 номер.

Ч.Гүнждагва: Мэдээллийг хүргэхдээ тухайн хорооны хэсгийн ахлагчаар дамжуулж энэ газрын урт удаан хугацааны дахин төлөвлөлтийн талаарх мэдээлэл, дэд бүтэцтэй холбоотой хэсгийн ахлагчдын үйл ажиллагаанд тусгагдсан 16 тэр ажилбарын хүрээнд бол энэхүү мэдээллийг бол иргэдэд хүргүүлдэг байгаа.

О.Номинчимэг: Отгоны Саранчулуун гишүүн дахиад тодруулъя.

О.Саранчулуун: Яах вэ? Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 10.1.2, 10.1.3 гэдэг заалтын хэрэгжилтийг л би асуугаад байгаа юм. Тэрэн дээр юу гэж байдаг вэ гэхээр аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах, иргэнийг татан оролцуулах,

урамшуулах гээд 10.1.4 гэдэг заалт дээр байгаа шүү. Та хэд өөрсдөө харах хэрэгтэй. Одоо энэ 10.1.4 гэдэг заалтын биелэлтийг би бичгээр авахыг хүсэж байна. Ер нь бүх Засаг дарга нараас, бүх одоо аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нар энэ дээр ямар ажил хийсэн юм бэ гэдэг дээрээс эхлэх хэрэгтэй.

Хэрвээ бид нар хууль дээр ингэж заасан бол биелэлтийн үр дүнг ирүүлсэн тайлан дээр нарийвчлан багцлаагүй учраас би тодруулж байгаа шүү. Тэгэхээр бичгээр авах хүсэлтэй байна.

О.Номинчимэг: НБОГ-ын дарга өнөөдөр ирээгүй юм уу уг нь яг хариуцаж байгаа асуудал нь шүү дээ. Тэгээд мэдээлэл өгчихгүй. Тэгэхээр Байгаль орчны яам, Нийслэл, Байгаль орчны яам бусад 21 аймгийнхаа энэ хуулийн хэрэгжилтийн явцыг мэдээллийг бичгээр гаргаад Саранчулуун гишүүнд өгөөрэй. Гол нь хуулийн хэрэгжилт бид нар хараад байгаа шүү дээ. Яг бид нарын энэ Өргөдлийн байнгын хороон дээр авч хэлэлцэж байгаа асуудлууд ерөөсөө 1 салбар яамны асуудал биш яалт ч үгүй олон яамны энэ уялдаа холбоо байж байж явдаг асуудлууд дундаа хаягдчихаад байдаг асуудал байгаа байхгүй юу. Тийм учраас ингээд олон талын оролцоотой энэ нь яаж байна тэр нь яаж байна юун дээр доголдол гарч байна гэдгийг бид нар гаргаж ирж хэлэлцэж байгаа юм.

Тэгэхээр энэ эрүүл мэнд нь чухал, орон нутгийн удирдлага чухал. Байгаль орчны яам ч чухал болчихоод байгаа. Энэ мэдээллийг гаргаж өгье.

Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд агаарын бохирдол болохоор бид нар ингээд мэдрээд байгаа юм. Одоо юу гэдэг юм агаарын бохирдлоо дуу чимээний бохирдлыг сонсоод байгаа юм. Хөрсний бохирдлыг болохоор мэдэхгүй байгаад байгаа юм. Тэгээд одоогоор бид нар чинь 500 мянга буюу нэг хагас сая шахам нүхэн жорлон байгаа юм байна шүү дээ. Тэгээд энэ хагас сая шахам нүхэн жорлонгийн яг хэд нь гэр хороололд буюу хувийн айл өрх, яг хэдэн албан байгууллага буюу амралтын газрууд баазууд хөдөө явахад бид нар мэдэрдэг шүү дээ. Хэд нь ААН-үүд байдаг юм. Ийм тоо 1 дүгээрт байна уу эхний асуултад.

Яагаад энийг асуугаад байна? Энэ статистик чинь бид нар нөгөө нэг бодлогоо ярихад аягүй чухал байхгүй юу. Тэгэхгүй бол бид нар чинь нөгөө Алсын хараа 2050 гээд нэг зузаан ном дээрээ энийгээ цогцоор шийднэ гээд биччихдэг. 2026-2030 оны Монгол Улсын хөгжлийн 5 жилийн хөтөлбөр дээрээ энийг цогцоор нь шийдчихнэ гээд биччихдэг. Тэгээд яг цогц шийдлүүд чинь юу юм бэ гэдгийг надаа хариулж өгөөч. Та хэдийн зүгээс цогц шийдэл чинь юу юм?

Хоёрдугаарт энэ арга хэмжээний биелэлт чинь зорилтот түвшнээс 4.2 хувиар бууруулсан гэдэг чинь нөгөө талаар харах юм бол 96 хувиа зорилгодоо биелээгүй гэсэн үг шүү дээ. Энэ чинь 4.2 гэж бага тоо харагдаж байгаа чинь бодит тоо чинь 96 хувь байхгүй юу. 95.8 хувь гэсэн үг.

Хоёрдугаарт, өнөөдрийг хүртэл яг нүхэн жорлон буюу энэ нүхэн жорлонг багасгах асуудлаар хэчнээн төгрөг улсын төсвөөс хөрөнгө оруулсан юм хэчнээн төгрөг. Надад сүүлийн 10 жилээр хэлээд өгөөч. Яагаад гэвэл бид нарт тэр мөнгө чинь хайран байна шүү дээ. Та нарын тайлантай 600 сая төгрөгтэй л нэг тоо байна. Өөр тоо алга.

Гуравдугаарт, 2020 онд байна уу даа. Би буруу санаагүй бол Эрдэнэт үйлдвэрийн ноогдол ашгаас 100 тэрбум төгрөгийг нь аваад ерөнхий боловсролын сургуулиудын нүхэн жорлонгууд шийднэ гээд мөнгийг нь авчихсан юм. Тухайн үед авч байсан нь юм болоод л байсан. Тэгээд энэ 100 тэрбум төгрөгийн үр дүнгийн гүйцэтгэл нь ямар байдаг юм, хэдэн төгрөгийг нь зарцуулсан юм, хэдийг нь авсан юм? Үүгээр хэчнээн жорлон шийдсэн юм бэ? Хичнээн сургуулиудын нийгмийн асуудлыг энэ мөнгөөр шийдсэн юм бэ гэдэг асуулт байна. Тэгээд ер нь товчлоод хэлэх юм бол нийтдээ энэ 500 мянган буюу хагас сая жорлон нөхөн жорлонг шийдэхийн тулд та нарт хэчнээн төгрөг хэрэгтэй байгаа юм? Энэ 2 цаасан дээр буучихсан байгаа цогц хөтөлбөрүүд дээр чинь хэдэн төгрөг одоогоор зарцуулчихсан байгаа юм, хэдийг зарцуулах юм, цогц хөтөлбөрүүд дээр чинь хаана, хаанахууд ажилладаг юм? Хэн ерөнхийд нь хариуцдаг юм гээд нэг ийм хэдэн асуулт эхлээд асуугаад дараа нь тодруулчихъя.

О.Номинчимэг: Маш тодорхой асуултууд асуулаа. Байгаль орчны яам хариулах уу? 8 номер.

Ш.Батбаяр: Шижир гишүүний асуултад хариулъя.

Нүхэн жорлонгийн тоог айл өрх ААН нийтийн эзэмшил гэсэн 3 ангиллаар гаргасан байгаа. Эднээс айл өрхийн нүхэн жорлонгийн тоо хамгийн их буюу 453457 жорлон байгаа бол ААН-үүд дээр 6356, нийтийн эзэмшлийн 669 ноль байна. Зарцуулсан тоо хөрөнгийн хувьд улсын хэмжээнд 2020-2022 онд нийт 8560 ширхэг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг барьсан байна. Эндээс гэр хорооллын нүхэн жорлонгийн стандартын шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд мөн 2020-2022 онд 7150 ширхэг нүхэн жорлонг мөн устгасан байна. Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр Азийн хөгжлийн БОАЖЯ хамтран хэрэгжүүлсэн гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төслийн хүрээнд мөн 1500 ширхэг сайжруулсан нолийг байршуулсан байна гээд нийт ер нь бол яг нэгтгэсэн байгаа байдлаар тоон мэдээлэл нэгтгэгдэж гараагүй байна. Тэгээд ерөнхий боловсролын сургуулиуд дээр зарцуулсан 100 тэрбум төгрөгийн задаргаа Боловсролын яамнаас гаргаж байгаа төсөл байгаа.

Тэгэхээр бидэнд тодорхой мэдээлэл ирүүлээгүй байна. Ерөнхийдөө бидэнд байгаа судалгаагаар түрүүн хэлсэнчлэн 18 аргаар нолийг шинэчлэхэд дунджаар 2-оос 4 сая төгрөгийн зардал гарна гэсэн тооцоо судалгаа байгаа. Тэгэхээр нийт энэ бол 18 аргачлалынхаа аль нэгийг нь сонгоод тухайн нутаг дэвсгэрийнхээ цаг уурын байдал орчны байдлаас шалтгаалаад аль нэгийг нь сонгоод явах боломжтой байгаа юм аа. Тэгэхээр энэ дээр яг бас нийт дүнгээр тоон судалгаа гараагүй байна.

О.Номинчимэг: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Ингээд нэгдсэн мэдээллүүд чинь байхгүй болохоор бид нар юуг төлөвлөх юм бэ? Юуг хэрэгжүүлэх юм? Дараа нь юун дээр анхаарах юм бэ гэдэг ингээд ойлгомжгүй болчхож байгаа байхгүй юу даа. Энэ чинь энгийнээр ярих юм бол ААН байгууллагууд чинь энэ тоонуудаа нэг болгож байж зорилго зорилтоо бий болгодог юм шүү дээ. Тэгээд та нар чинь ингээд 1 дүгээрт нэгдсэн мэдээлэл байхгүй юм байна.

Хоёрдугаарт алсын хараа-2050, Монгол улсын хөгжил 2026-2030 оны хөтөлбөр, 2024-2026, 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр ЗГ-ын гээд. Энэ дээр чинь бүгдийг нь цогц төлөвлөгөө биелүүлэлт, цогц арга хэмжээнд хэрэгжүүлнэ гээд заачхаад байгаа байхгүй юу даа. Энэ цогц арга хэмжээ чинь юу юм бэ? Яаж хэрэгжүүлж байгаа юм бэ гэж асуугаад байна шүү дээ. 2028 онд чинь ингээд нэг жил зургаахан сарын дараа дууслаа.

Тэгэхээр цогц арга хэмжээ чинь хэрэгжсэн байна гэсэн үг шүү дээ. Нэг жил 6 сарын хугацаанд. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээнүүд яаж хэрэгжүүлж байгаа юм бэ гэж асуугаад байгаа юм. Тэгээд алийг нь хариулах юм бол доо Байгаль орчны яам гэхээр биш болчхоод байх юм. Нийслэл гэхээр биш болчхоод байх юм. Боловсролын яам гэхээр мэдээлэл нь байхгүй гээд байх юм алийг нь хариулах юм дарга аа?

О.Номинчимэг: Ингээд харин яг ийм асуудлууд тухайлсан нэгхэн яамны эрхлэх асуудал биш болчхонгуут ингээд хаягдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр энэ хөтөлбөр дээр туссан цогц арга хэмжээ гэдгийг яаж тодорхойлж аль аль яам ямар оролцоотой хоорондоо уялдаа холбоотой байгаа гэдэг Засгийн газрын түвшинд яригдаад хэлж байгаа юм байна уу? Орон нутгийн түвшинд ирсэн мэдээлэл нь байна уу? Байгаль орчны яаман дээр энэ мэдээлэл байна уу? Цогц арга хэмжээ гэдэгт ямар ямар арга хэмжээгээ тодорхойлж энэнийхээ хэрэгжилтийг та бүхэн маань хангаж тайлагнаж байгаа вэ гэдэг дээр.

8 номер уу? 8 номер.

Г.Энхмөнх: Мэдээлэлд дурдсанчлан аймаг нийслэлийн удирдлагуудтай Байгаль орчин, уур амьсгалын сайдын хийж байгаа гэрээн дээр хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр нолийн тоог бууруулах гэрээг хийгээд явж байгаа. Тэгээд тэр төлөвлөгөөний дагуу сая хэлсэнчлэн 2028 он хүртэл төлөвлөгөө гаргаад явж байгаа. Хэрэгжилт маань харин хангалтгүй. Орон нутгаас энэ төсвийг нүхэн жорлонг бууруулах төсвөө тавьж өгөхгүй байгаа. Зарим тохиолдолд мэдээллээ ч ирүүлэхгүй байгаад байгаа талууд байгаа. Ер нь нийтийн ариун цэврийн байгууламжийн асуудал байна. Барилга, хот байгуулалтын яамны эрхлэх асуудалд хамрагддаг.

Тэгэхээр манайхаас нүхэн жорлонгийн байгаль орчин хөрсөнд үзүүлж байгаа нөлөөллийг бас тодорхой хэмжээгээр нөлөөллийн үнэлгээг хийж холбогдох байгууллагуудад хүргүүлдэг. Тэгээд энэ улсын хэмжээнд байгаа ноль нүхэн жорлонгийн тоо судалгааг 2025 оны байдлаар шинэчлэн гаргасан. Тэгээд энэ асуудлуудаа холбогдох байгууллагуудтай мэдээллээ хуваалцаад ажиллаж байгаа олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд тодорхой ажлуудыг хийж байна. Мөн түрүүн хэлсэнчлэн.

О.Номинчимэг: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Энэ нөгөө нэг хагас сая жорлонгийн чинь 45340 нь гэр хороолол юм байна шүү дээ. Тэгэхээр би юу гэж асуух гээд байна гэхээр БХБЯ-тайгаа яаж хамтарч ажиллаж байгаа юм бэ? Яг энийг хамгийн үр дүнтэй бууруулах арга хэмжээ ерөөсөө л орон сууцжуулалт шүү дээ. Орон сууцад хамрагдаж байж энэ утааны бохирдол чинь буурна, хөрсний бохирдол чинь буурна. Тэгэхээр энэ дээр барилга орон сууцын яамтайгаа яаж хамтарч ажиллаж байгаа юм гэдгийг дахиад асууя. Одоо энэ жишээ нь 2025 онд 7 хувь буюу 34826, 2027 онд 20.9 хувь буюу 10331,

2028 онд 49.9 хувь буюу 247 мянгыг нүхэн жорлонг устгана буюу байхгүй болгоно оо гээд ингээд зорилт тавьчихжээ. 2028 он чинь дахиад жил зургаахан сарын дараа дууслаа. Энэ хугацаанд бид нар 300 мянган нүхэн жорлонг устгасан байх юм байна аа. Ийм боломж байгаа юм уу? Энэ бодит тоонууд чинь ингээд худлаа тоонууд байна шүү дээ. Энэ төлөвлөгөө төлөлт хоёроо эргэж харахгүй юм уу? Нэг нь төлөвлөсөн болоод нөгөөдөх нь авсан болоод дуусаад.

О.Номинчимэг: Зорилго зорилт бодитой юу? Нийслэлээс тэр орон сууцжуулалттай холбоотой хийж байгаа ажлын үр дүн, ямар тоо, тооцоо төлөвлөгөө байгаа гэдгээ нэг хэлчихвэл одоо яг гол энэ орон сууцжуулалтын асуудал бол нийслэл хотод нэлээн эрчимтэй явж байгаа. Хөдөө орон нутаг аймгийн төвүүд дээр ч гэсэн явж байгаа. Энэнийхээ тоог хэлчхээрэй. Бодит байдал дээр нүхэн жорлонгоо зөвхөн юу гэдэг юм энэ 13 аргачлалын дагуу био нүхэн жорлон руу солиод явах юм уу ингэхээр гүйцэж байна уу гэдэг дээр. 8 номер уу хэд вэ? 9 номер уу? 9 номерын микрофон өгье.

Г.Энхмөнх: Шижир гишүүний асуултад хариулъя аа.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын газрын дарга Энхмөнх байна аа. Хог хаягдлын тухай хууль дээр энэ хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр Засаг даргын эрх үүрэг дээр маш тодорхой заалт байж байгаа. Энэ хөрсний бохирдлыг бууруулах хүрээнд стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонг үе шаттайгаар бууруулна гэж байгаа юм. Энэ хүрээнд бид 21 аймаг болоод НЗДТГ, Засаг даргаас бол 2028 он хүртэл энэ стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонгоо хэрхэн шийдэх юм бэ? Ямар үе шаттайгаар явах вэ гэдэг байдлаар нэг бүрчлэн нарийвчилсан төлөвлөгөөг нь аваад нэгтгэсэн. Энэ хүрээнд бол аймгийн нийслэлээс нүхэн жорлонг 2025 онд тэдэн хувиар, 2026 онд тэдэн хувиар гэдэг юм уу энэ бүх мэдээллүүдийг ирүүлсний үндсэн дээр бид мэдээллийг нэгтгэн гаргасан.

Нөгөө талаасаа нүхэн жорлонгоос илүү нөгөөтээгүүр энэ ойн болон ус.

О.Номинчимэг: 9 номер гүйцээгээд хариулъя.

Г.Энхмөнх: Энэ ийм байгаа. Манай гаргасан төлөвлөгөөгөөр бол 2028 он гэхэд одоо байгаа стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонгийн 50.7 хувийг бол стандартын шаардлага хангуулна гэсэн ийм л төлөвлөгөө байж байгаа.

О.Номинчимэг: Энэ нөгөө та бүхний ирүүлсэн яг мэдээлэлтэй, тайлантай холбоотой асуулт байна. Тэрийг нь тодруулаад хэлчих үү? Хөрсний нянгийн бохирдол гэсэн хэсгийн 4 дэх параграф дээр байгаа юм байна. Энэ төлөвлөгөөгөөр 2024 оны байдлаар ийм хувийн 495 мянган нүхэн жорлонгоос 2025 онд 7 хувь, 2026 онд 15.6 хувь, 2027 онд 20 хувь, 2028 онд 49.9 хувиар бууруулахаар зорилтоо хийсэн юм байна. Гэхдээ хэрэгжилт хангалтгүй хэвээрээ байгаа юм гэдэг юм л ярьж байгаа юм байна тийм үү? Тэгээд зорилт тавьсан юм байна гэхдээ хэрэгжилт хангалтгүй. Яагаад хэрэгжилт хангалтгүй байгаа асуудлууд байна гэдгээ 9 номер.

Г.Энхмөнх: Тодруулъя. Энэ өөрсдийнх нь ирүүлээд төлөвлөчихсөн мэдээлэл дээр үндэслээд бид хэд бууруулахдаа хувийг нь гаргасан. 2025 онд 7 хувь гэж байгаа хэдий ч гэсэн 2025 оны гүйцэтгэлээр бол 4 хувиар л бууруулсан байж байгаа. Ингэхээр өөрсдийнхөө төлөвлөж ирсэн төлөвлөгөөний дагуу бууруулах ажил нь хийгдэхгүй байна л гэсэн үг орон нутгаас.

О.Номинчимэг: Яах вэ нөгөө хийгдэхгүй байна гэдэг нь ямар учир шалтгаантай юм? Ер нь нэгдсэн бодлогоор хангаж байна уу? Хоорондоо уялдаа холбоотой байж нэг жоохон том өргөн зургаар нь бид нар яримаар л байгаа юм. Гэхдээ өнөөдөр ирсэн хүрээнд мэдээлэл нь ийм байна.

Чинбатын Ундрэм гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Орчны бохирдол бол олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа. Тэгээд үүний хамгийн том 2 хүчин зүйл нь энэ нүхэн жорлон, хог хаягдал 2 байгаа. Тэгээд нүхэн жорлонгийн хувьд 2020-2024 онд миний бие санаачлаад Их Хурлын эмэгтэй гишүүдтэйгээ энэ 800 сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг 21 аймагт байгаа. Энийг бүгдийг нь орчин үеийн ариун цэврийн байгууламж болгоё оо. Энэ бол нийгмийн эрүүл мэндийн талаасаа ч тэр, хүүхэд хамгааллын талаасаа ч тэр хүүхдүүд дотуур байр нь 6 настай айлын хүүхэд малчны хүүхэд ирээд шөнө үдэш нүхэн жорлон руугаа орох гэж байгаад тэнд хүчирхийлэлд автдаг, унаж бэртдэг, ойчдог, айдаг гээд ингээд ийм асуудлууд байсан юм. Тэгээд мөнгө хайгаад бид нар хайсаар байгаад Эрдэнэт үйлдвэрээс боломж байна уу гээд. Ингээд 160 тэрбум төгрөг зориулаад тэгээд сум болгонд өөр өөр зураг төсөв, өөр өөр хөрсний нөхцөл байдал мөн ачааллын хувьд өөр өөр ийм нөхцөл байдалд бүгд дээр нь бид нар ингээд 4 жилийн хугацаанд хийгээд үндсэндээ хамгийн сүүлийн 100 хүрэхгүй сургууль цэцэрлэгийн нүхэн жорлон шинэчлэгдээд дуусаж байгаа юм. Тэгээд ямар ч л байсан боловсролын салбар энэ жилийн 9 сарын 1 гэхэд нүхэн жорлонгүй болж байгаа. Тэгээд энд бид нар 160 тэрбум төгрөг тэгээд ингээд нийт бараг 5 жил зарцуулж байж ард нь гарч байгаа юм.

Тэгээд сая нөгөө Шижир гишүүн ямар төлөвлөгөө яаж та нар энийгээ бууруулах юм бэ гээд асуугаад байгаа. Надад бол энэ 800 жорлон бол тун хэцүү байсан. Маш их мөнгө бид нар олж цуглуулж араас нь хөөцөлдөж Барилгын яам, Боловсролын яамтай хамтарч ажиллаж байж ингээд ард нь гарч байгаа юм.

Тэгэхээр та хэд маань яаж гарах юм байгаа юм. Дараагийн миний санаа зовж байгаа юм нь эрүүл мэндийн энэ төвүүд байгаа байхгүй юу. Нийт 21 аймгийн сумдад байгаа ЭМТ-үүдийн 70 хувь нь гадаа нүхэн жорлонтой. Тэгээд энэ бүүр нүхэн жорлонд эмэгтэй хүн амаржих гэж байгаад тийшээ хүүхдээ унагаасан тохиолдол хүртэл байдаг байхгүй юу. Тэгэхээр бид нар яаралтай энэ ЭМТ-үүдээ орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгохгүй бол болохгүй ийм нөхцөл байдалтай байгаа. Тэгэхээр энэ Орчны бохирдлын үндэсний хороо гэдгийг чинь хэн ахалдаг юм бэ? Тэр хүн чинь хэзээ хамгийн сүүлд хурлаа хийсэн юм бэ? Тэр төсөв мөнгө тэрэнд нь хэн хэн аль сайд нар ордог юм бэ? Энэ дээр нэг хариулж өгөөч.

Дээрээс нь бид нар энэ ААН-үүд гээд 6556 ААН нүхэн жорлонтой гэж байна шүү дээ. Эд нарыхаа ариун цэврийн байгууламжтай болох шаардлага тавиач. Наад зах нь энэ ШТС-ууд энэ 21 аймгаар тарчихсан байгаа бүгдээрээ нүхэн жорлонтой. Эд нар чинь орлого олж байгаа, ашиг олж байгаа байгууллагууд. Яагаад орчин үеийн ариун цэврийн байгууламж байгуулаад ингээд ард иргэдэд үйлчлээд төлбөр авч болно шүү дээ тэрэндээ тиймээ. Ингээд шаардлага тавих хэрэгтэй байна аа. Нэг минутаа нэмээд авчихъя.

О.Номинчимэг: Ундрэм гишүүн нэг минут.

Ч.Ундрам: Тэгээд би сая Аялал жуулчлалын сайдаар ажиллаж байхад аялал жуулчлалын мэргэжлийн холбоотойгоо яриад аялал жуулчлалын байгууллагууд маань бүгдээрээ орчин үеийн ариун цэврийн байгууламжтай больё оо гээд ингээд 6 хувийн хүн хөнгөлөлттэй зээл 250 тэрбум гээд банкнуудаар дамжуулаад өгч байгаа. Энэ дотроо бид нар зам дагуух үйлчилгээний 58 цэгийг байгуулах, хүн 2 цаг тутамд 200-аас 250км тутамд амрах ёстой. Тэгээд Урьхан шиг тийм үйлчилгээний төвийг ариун цэврийн байгууламжтай тэндээ хоол хүнсээ авчихдаг нутгийн иргэдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулчихдаг ийм цэгийг байгуулахад 6 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай ийм зээлийг олгохоор шийдүүлсэн байж байгаа.

Тэгэхээр энэ жилээс эхлээд ийм ариун цэврийн байгууламж бүхий цэгүүд байгуулагдана аа. Яг энэ шиг бас бүх салбарын сайд нар ингээд анхаараад эхлэх юм бол энэ асуудлыг хурдтай шийдэх боломж байна.

О.Номинчимэг: Ундрам гишүүний асуултад хариулъя. Орчны бохирдлын үндэсний хорооны мэдээлэл байгаль орчин дээр л байгаа болов уу даа, мэдэх үү? 9 номерын микрофон.

Н.Эрдэнэбаяр: Гишүүний асуултад хариулъя аа.

Орчны бохирдлын үндэсний хороо бол татан буугдсан. Одоо байгаа хороо бол зөвхөн Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо гээд явж байгаа. Орчны бохирдлын үндэсний хороо бол 2023-2024 оны хооронд татан буугдсан байж байгаа.

О.Номинчимэг: Орчны бохирдлын үндэсний үндэсний хороо ямар ямар сайдын бүрэлдэхүүнтэй байгаад ямархуу үйл ажиллагаа, үр дүнтэй үйл ажиллагаа хийж шийдвэрүүд гарч байсан бэ гэдэг асуултад хариулъя. Ундрам гишүүний.

Хоёрдугаарт тэр ААН-үүдэд шаардлага эд нар өгч байгаа юм уу? Байгаль орчны яамнаас. ААН-үүд маань өөрөө нүхэн жорлонтой энэ дээр ер нь хэн нь шаардаж байна? Эсвэл хаячхаад, тоо гаргачхаад л суугаад байна уу гэдэг дээр яая.

Гуравдугаарт Ундрам гишүүний асуусан ЭМТ-ийн юун дээр эрүүл мэндийн байгууллагынхан ямар төлөвлөгөөтэй байна? Асуудал нь юу байна? Одоо ингээд нэгэнт бид нар сонсоод өнгөрөх биш цаашаа арга хэмжээ авахаар бол Өргөдлийн байнгын хороо ажиллана. ЭМТ-үүдийн орон нутгийн нүхэн жорлонгийн асуудал дээр та хэд ямар арга хэмжээ хийх гэж байна гэдэг энэ асуулт дээр бүрэн хариулъя. 9 номер.

Г.Энхмөнх: Ундрам гишүүний асуултад тодруулга өгье өө.

Хуучин Орчны бохирдлын үндэсний хороог тухайн үеийн БОАЖ-ын сайд ахлаад ингээд ажлын албатай байсан. Тухайн үед төсөв л зарцуулах төсөвтэй. Энэ хүрээн дотроо бол агаарын бохирдол, хөрсний бохирдол, хог хаягдлын асуудал хамрагдаад явдаг байсан юм байна лээ. Ингээд үндсэндээ үйл ажиллагааны үндсэн чиглэл нь бол Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр гэж байсан. Энэ хөтөлбөрт орсон ажлуудыг бол санхүүжүүлээд хэрэгжилтийг нь хангаад явдаг ийм бүтэц зохион байгуулалт байсан байна лээ. Энэтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл байгаа. Шаардлагатай бол бид хуучин хийгдэж байсан Орчны бохирдлын үндэсний хорооны дэлгэрэнгүй мэдээллийг танд хүргүүлье ээ.

Дараагийнх нь ШТС-тай холбоотой мэдээлэл явсан. Бид 2023 онд улсын хэмжээнд ШТС.

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя. 9 номер.

Г.Энхмөнх: Улсын хэмжээнд байгаа ШТС-уудад нэгдсэн судалгаа хийсэн. Ингэхэд 1222 ШТС-аас боловсон ариун цэврийн байгууламжтай 140, эко ариун цэврийн байгууламжтай 650, нүхэн жорлонтой 435 ийм байдалтай нөхцөл байдал байна гэдгийг тогтоогоод ингээд үндсэндээ 2024 онд бүх аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад сайдын нэгдсэн албан даалгавар гаргаж хүргүүлсэн. Энэ албан даалгаврын хэрэгжилтийг бол 2025 онд дүгнэж үзэхэд 62.5 хувийн гүйцэтгэлтэй байна гэсэн ийм дүн гарсан. Ингээд үндсэндээ тухайн ШТС-уудыг ариун цэврийн нэгдсэн байгууламжуудаар хангахын тулд энэ аймаг нийслэлээс хийгдэж байгаа ШТС дээр хийгдэж байгаа ерөнхий үнэлгээний дүгнэлтэд нь зайлшгүй тусгуулах, нөгөө талаасаа аймагт энэ хяналтыг хэрэгжүүлж байгаа салбар хяналтын газруудыг ажиллуулах.

О.Номинчимэг: ЭМЯ 5 номер.

Н.Эрдэнэбаяр: Ундрам гишүүний асуултад хариулъя аа.

Энэ сумын эрүүл мэндийн байгууллагууд ЭМТ буюу энэ эрүүл мэндийн байгууллагуудын 79 байгууллага нь яг энэ нүхэн жорлонтой байгаад байгаа. Энэ дотроо 2 янз байгаад байгаа юм. Зарим нь болохоороо одоо тэр суман дээрээ дэд бүтцээ шийдээд ингээд орчин үеийн ариун цэврийн өрөөтэй боловч давхар нүхэн жорлонгоо ашиглаад байдаг ийм системтэй. Өөрөөр хэлбэл тэр цэвэрлэх байгууламж юмнууд нь ингээд сайн ажилладаггүй ийм сумууд байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нар Эрүүл мэндийн яамнаас бол яасан бэ гэхээр бас энэ нэлээн их зардал гарах юм байна лээ тооцоолууд хийгээд үзэхээр. Ингээд ДЭМБ суурин төлөөлөгчийн газраас Адаптэйшин сан дээр 15 сая долларын ийм төсөл бичээд явуулчихсан байгаа. Одоогоор хариу ирээгүй байна. Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээн дээр бид нар бас яг энэ нүхэн жорлонгүй эрүүл мэндийн байгууллагатай больё оо гээд яг төсөл эцэслэгдээгүй байгаа. Одоо энэ дээр нэг 10 тэрбум төгрөг тавьчихсан явж байгаа. Яг нэг ч амьсгаагаар шийдчихнэ гэхэд үнэхээр хүндрэлтэй ийм зардал шаардагдаад байгаа учраас ер нь бид нар.

О.Номинчимэг: Ундрам гишүүн тодруулъя.

Ч.Ундрам: Тэр Орчны бохирдлын үндэсний хорооны тайланг ер нь авъя. Тэгээд шаардлагатай бол бид нар Байнгын хорооны тогтоол ч юм уу гаргаад энийг дахиж байгуулахгүй бол маш хүнд нөхцөл байдалд энэ орчны бохирдол оччихсон байгаа. Нэмж асуух нэг асуулт байна аа. Энэ хог хаягдалтай холбоотой энэ хүнд металл бүхий хортой хог хаягдал, нөгөө хортой хог хаягдлын хууль гэж байдаг санагдаад байх юм. Тэрний хэрэгжилтийн хүрээнд энэ Төв аймгийн Сэргэлэн сумд газар аваад тэндээ энэ хог хаягдлыг ангилах яадаг юм байгаа юм байгаа юм дахин боловсруулах ч байдаг юм уу устгах ийм нэг цэг баригдах ажил өнгөрсөн парламентын хугацаанд явж байгаад тэгээд таг чиг болчихсон. Тэр асуудал ер нь ямар түвшинд явж байгаа юм бол? Энэ бол Байгаль орчны яамны гол хариуцах асуудал гэж би бодож байна. Эндээс чинь энэ үйлдвэрийн хүнд металлууд болон бусад хог хаягдал шийдэгдэх ёстой юм биш үү.

О.Номинчимэг: Тэр Үндэсний хорооны мэдээллийг Ундрам гишүүн бичгээр явуулаарай. Аюултай хог хаягдлын асуудал дээр 9 номерын микрофон.

Г.Энхмөнх: Ундрам гишүүний асуултад тодруулга өгье өө. Хуулийн хувьд бол Хог хаягдлын тухай хууль гээд нэгдсэн байдлаар явж байгаа. Ингээд дотроо ангиллын хувьд бол энгийн болон аюултай хог хаягдал гэсэн үндсэн ангилал байж байгаа. Таны асуусан аюултай хог хаягдлын нэгдсэн байгууламж гээд байгаа нэгдсэн байгууламж нь Төв аймгийн Сэргэлэн сумд барихаар төлөвлөсөн. 2022 онд тухайн газрыг 20 га талбайгаар улсын тусгай хэрэгцээнд авсан. Ингээд авсны дараа бол үндсэндээ тухайн газрын байгаль орчны төлөв байдлын суурь судалгааг хийгээд ингээд бид энэ жил тухайн нэгдсэн бүтээн байгуулалттай холбоотой эдийн засгийн судалгааг нь хийгээд дууссан. Хуучин техник эдийн засгийн үндэс нь бол 2019 онд хийгдсэн байдаг. Одоо энэ нэгдсэн бүтээн байгуулалтыг бид Эдийн засгийн хөгжлийн яамтай хамтраад төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх гээд явж байгаа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалтад хамрагдчихсан байж байгаа. Ингээд бид ямар ч байсан.

О.Номинчимэг: Баярлалаа. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ер нь манай улсын аль ч салбарын ажил хөрсөн дээрээ биш цаасан дээр явдаг нь энэ байдлаас харагдаж байна. Ер нь ингээд агаарын бохирдол дээр ямар үр дүн гарсан бэ гэнгүүт хариулах хүн байдаггүй тиймээ. Үр дүн гэдэг юм бол ярих ямар ч боломжгүй ийм байдал хаа хаанаа байна аа. Тэгээд ер нь боловсролын салбарын сая жишээ нь Ундрам гишүүн хэлж байна. 800 гаруй нүхэн жорлон сургуулиуд байдаг аа. Сумдын сургууль, дотуур байр гээд. Эд нарыг манай эмэгтэй гишүүдийн санаачилгаар ингээд асуудлыг бүрэн шийдсэн. Тэгэхээр энэн дээр сэтгэл гаргаад ажиллавал болохгүй юм байхгүй гэдэг нь харагдаж байна.

Миний асуух асуулт болохоор сүүлийн 3 жилд хөрсний бохирдол бууруулахад хэдэн төгрөг зарцуулсан бэ? Ямар үр дүн гарсан бэ гэдгийг асуумаар байна. Сүүлийн 3 жилд.

Хоёрдугаарт нь энэ ногоон зээлийн дэмжлэг ногоон зээлийн санхүүжилтэд ингээд 2026 онд 600 сая төгрөгийн зээлийн татаасын гэрээ байгуулсан л гэнэ. Бас нэг 800 гаруй сая төгрөг байна л даа энэ дээр энэ тоон мэдээлэл дээр. Тэгэхээр энэ яг одоо зээлүүд яг бодит иргэдэд хүрч байна уу? Хэн нэгэн авангуутаа өөр юманд зарцуулаад байна уу гэдэг ийм мэдээлэл сонсмоор байна. Баахан л төсөл хэрэгждэг шүү дээ Монгол Улсад. Тэгээд тэр төсөл нь дандаа цаасан дээр хэдэн зураг аваад л тэгээд л болоо үр дүн байхгүй. Хэрвээ энэ олон 2010 оноос ногоон технологи л гэнэ 2019 оноос ногоон зээл гэнэ. Энэ олон төсөл хөтөлбөрүүд хэрвээ хэрэгжсэн бол өнөөдөр агаарын бохирдол хөрсний бохирдол нэлээн олон хувиар буурсан байх ёстой шүү дээ яаж ч бодсон.

Гэтэл ингээд нэг л олон сайхан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэрээр хэсэг бүлэг мэдээлэлд ойр хүмүүс энэ зээлийг нь аваад өөр юманд зарцуулдаг юм уу гэсэн хардлага байна. Тэгээд үр дүн байна уу гэхээр та нар дотроос хариулах хүн бараг байхгүй байна шүү дээ. Тэгээд нэг цаас харж унших хөрсөн дээрээ бууж ажиллах 2 чинь өөр шүү дээ. Яг үнэндээ ажлаа тас хийтэл ингээд хийсэн ажлаа тайлагнаад хариулах хүн бараг байхгүй байна. Түрүүн Шижир гишүүн хэд хэдэн удаа асуулаа шүү дээ. Хариулт байхгүй мэдэж байгаа хүн байхгүй. Мэддэгүүд нь

эсвэл ирж хариулах дургүй байдаг юм уу, мэдэхгүй хүмүүсээ зориод явуулчихдаг юм уу гайхаж байна яг үнэндээ.

Тэгээд энэ ногоон зээл өгдөг гээд байх юм. Иргэдэд энэ нь хир хүртээмжтэй байна. Энэ нийслэл хотод 50 гаруй хувь нь нүхэн жорлонтой байна гэж байна шүү дээ. Тэгээд энэ нүхэн жорлонгуудыг хэзээ бууруулах юм. Ямар ч тоо судалгаа байхгүй. Зүгээр ингээд нэг тэгнэ ингэнэ ингэнэ гээд олон жил бид нар дандаа нэг ирээдүй цаг дээр яриад сурчихсан байна. Тэгсэн ингэсэн ийм үр дүн гарсан бид нар ийм ажил хийж байна төлөвлөж байна гэсэн юм энд харагдахгүй байна.

О.Номинчимэг: Байгаль орчны яам сүүлийн сүүлийн 3 жилд гаргасан төсөв, үр дүн нүхэн жорлонтой холбоотой гэсэн тиймээ. 9 номер уу? 9 номерын микрофон.

Ч.Гүнждагва: Нүхэн жорлонтой холбоотой хариултыг өгье.

Энэ Орчны бохирдлын үндэсний хороо байгуулагдаад ингээд үндсэндээ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр гээд явж байгаа. Хөтөлбөрийн зардал бол үндсэндээ сүүлийн 3 жилийн дүн бол 4-6 тэрбум төгрөг орчим төгрөг тавигдаж байгаа. Эндээс хог хаягдлыг аюултай хог хаягдлыг хадгалах агуулах агаарын бохирдлыг бууруулах, энэ дотор бол хөрсний бохирдолтой холбоотой зардлын хувьд бол 2024 онд бид энэ усны энгийн болон онцгой хамгаалалтын бүсүүдэд байгаа хог хаягдлын цэгүүдийн зураглалыг гаргасан. Ингээд үзэхэд бол онцгой хамгаалалтын бүсэд 36 энгийн хамгаалалтын бүсэд 24, эрүүл ахуйн бүсэд 8 гэх мэтчилнээр энэ нь цаашлаад гол ус бохирдуулах хөрс бохирдуулахад ийм эрсдэлтэй байгаа гэдэг үүднээс ингээд 2024 онд тэрбум 200 мянган төгрөг гаргаад ингээд шийдвэрлэсэн. 2025 оны хувьд бол лабораторийн хүчин чадал сайжруулах хүрээнд Байгаль орчны төв лабораторид 800 сая төгрөгөөр 30 нэр төрлийн хүнд металлыг хэмжих багаж тоног төхөөрөмжөөр хангасан. Мөн энэ улсын хэмжээнд 1100 мониторингийн нэгдсэн цэг бий болгох ажлыг 400 сая төгрөгөөр хийсэн. Ингээд үндсэндээ 2024, 2025 онуудад 1 тэрбум 200, 2025 онд тэрбум 200 мянган төгрөгийг нь зарцуулсан байна.

Энэ жилийн хувьд бол хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр өнгөрсөн онд тогтоосон бохирдсон хөрсийг нөхөн сэргээхтэй холбоотой асуудлаар шинжлэх ухааны хүрээлэнгүүдтэйгээ хамтраад жишиг 5 төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлээд байгаа. Энэ дээр үндсэндээ 200 сая төгрөг л төсөвлөгдсөн байж байгаа. Бусад зардлын хувьд бол өмнөх онуудын өрийг ингээд барагдуулаад дуусаж байгаа. Ийм л дүн мэдээ байж байгаа.

О.Номинчимэг: Мөнхтуяа гишүүн тодруулъя.

Ц.Мөнхтуяа: Тэгээд зун бороо ус ороод эхлэнгүүт нөгөө нүхэн жорлонгуудынх нь баас шээс үер хүчтэй аадар бороо ороход нөгөө хотоороо нэг урсдаг энэ асуудлыг хэзээ байхгүй болгох юм. Энэ зүгээр аюултай тэгээд л энэ дараа нь ингээд гэдэсний янз бүрийн халдварт өвчнүүд гарч байгаа шүү дээ. Тэгээд эндээс урьдчилан сэргийлэх яг ямар ажил хийгддэг юм? Жил болгон л бороо орно, жил болгон л хотоор энэ баас шээс нь хөвөөд явж байна. Энийг одоо тэгээд яаж таслан зогсоох вэ? Энэ бол маш ноцтой асуудал гэж би харж байна. Тэгэхээр энэ дээр бас ямар арга хэмжээ авдаг юм?

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? Нийслэлээс хариулах уу? Хийж байгаа ажлаа нийслэлийн хэмжээнд. 2 номер.

Ч.Гүнждагва: Мөнхтуяа гишүүн болон түрүүн Шижир гишүүний асуусан дээр Нийслэлээс өөрсдийнхөө энэ хэрэгжүүлж байгаа төлөвлөгөө цогц арга хэмжээний талаар тодорхой мэдээллийг өгье өө.

Нийслэлээс 2025-2032 онд гэр хорооллыг орон сууцжуулах төлөвлөгөөний хүрээнд 49800 нүхэн жорлонг байхгүй болгоно гэсэн ийм төлөвлөгөөтэй байж байгаа. Өнгөрсөн 2025, 2026 он дамнаад одоогийн байдлаар Сэлбэ, Баянхошуу, Ногоон нуур энэ дахин төлөвлөлтийн хүрээнд 3500 ширхэг нүхэн жорлонг байхгүй болгосон байж байгаа. Энэ ажил маань ингээд 2032 он хүртэл дэс дараалалтай ингээд явах юм бол нийтдээ 49800 нүхэн жорлонг байхгүй болгоно. Агаарын бохирдлыг 47.3 хувиар бууруулах ийм төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байгаа.

Дээр нь Улаанбаатар хотын захирагчийн албаны албанаас урсгал зардлаасаа хөрсний бохирдол болон нүхэн жорлонг.

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя. 2 номер.

Г.Энхмөнх: Нүхэн жорлонгийн ариутгалтай холбоотойгоор бол 2026 онд 400 сая төгрөг төсөвлөсөн. Энийгээ бол 6 дүүрэг бол энэ дээрээ тендерээ зарлаад одоо энэ үйл ажиллагаа явагдаж байгаа. Мөн хөрсний бохирдолтой холбоотойгоор Самбалхүндэв оршуулгын газар дээр өнгөрсөн он 2026 онд 15 тэрбум төгрөг тавьсан. Үүнтэй холбоотойгоор бол 20 га газрыг чөлөөлөх ажиллагаа тендер нь зарлагдаад ингээд эхлээд явж байгаа. Өнгөрсөн жил 10 га гэж үзсэн.

О.Номинчимэг: Мөнхтуяа гишүүн тодруулъя.

Ц.Мөнхтуяа: 47.3 хувь бууруулна гээд төлөвлөгөөтэй явж байна, ажиллаж байна гэж байна шүү дээ. Тэгэхээр одоо яг хэдэн хувьтай явна? Төлөвлөгөөнийх нь.

О.Номинчимэг: 2 номер Гүнждагва дарга.

Ч.Гүнждагва: Одоогийн байдлаар Сэлбэ, Баянхошуу, Ногоон нуурын дахин төлөвлөлттэй холбоотойгоор энэ төлөвлөлттэй холбоотойгоор 3500 нүхэн жорлонг байхгүй болгосон байгаа. Чөлөөлчихсэн болчихсон. Энэ бол чөлөөлөөд газрыг нь ариутгаад ариутгал хийгдээд ингээд явж байгаа. 2032 он хүртэл нийтдээ нүхэн жорлонг 49800. Агаарын бохирдлын хувьд бол яг нийтдээ 47.3 хувиар бууруулна гэж байгаа. Тэгэхээр яг энэ дээр яг тодорхой яг үнэн зөв тоо. Би яг одоо өгөх боломжгүй байна.

О.Номинчимэг: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Уг нь чухал сэдэв байна аа. Манай яамдуудын ажлын уялдаа хэрхэн явж байгааг хариултуудаас харж байна аа. Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын үед хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн тоо статистикийг ч гэсэн тайлагначхаж чадахгүй мэдэхгүй л байна л даа. Харамсалтай нь. Тэгээд 1 Засгийн газар шүү дээ. Тэгээд орж ирчхээд бие биеэ хараад бид мэдэхгүй гээд байдаг. Энэ хөрсний бохирдолтой тэмцэх энэ үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллүүд уг нь тодорхой нэг институц нь хийгээд цуглуулаад тайлан болгох л ёстой. Тэгээд ерөөсөө хангалтгүй байгаа нь харагдаж байна. Сэтгэл гаргахгүй байна.

Хоёрдугаарт ер нь зүгээр ийм том төлөвлөгөөнүүд хэлж байна. Засаг дарга орон нутагт үүрэг өгчихсөн гээд манай Байгаль орчин, уур амьсгалын яам хэлж байна. Тэгэхдээ би ганцхан зүйлийг л хэлэх гэсэн юм. Гол асуудал маань яах вэ Засаг дарга орон нутагт үүрэг өгч болно оо. Энэ үүрэг өгөхийн хэрээр энэ хууль эрх зүйн орчин бөгөөд энийг хэрэгжүүлэх чиг үүргийг дагасан процесс ерөөсөө байхгүй байгаад байгаа байхгүй юу. Процессын санд цаана нь ажлыг уялдуулах тодорхой үүрэг байдаг юм уу эрх мэдэл байдаг юм уу эсвэл энийг дагасан төсвийн хуваарилалтын асуудал байгаа юм.

Тэгэхээр манай энэ Байгаль орчны яам сүүлийн 20 жил энэ менежмент дээрээ төөрчихсөн. Ерөөсөө энэ хууль эрх зүйн орчнуудыг бүгдийг нь салгаад гаднын төсөл хөтөлбөрүүдээр байгаль орчныг хамгаалах хуулиудыг жижиглээд л хууль батлаад байдаг. Ямар ч хэрэгжилтгүй хуулиуд тэгээд энийгээ зогсоогооч. Тэгээд шинэ удирдлагын баг ирсэн байна. Би энэ дээр нэг өөрчлөлт гараасай гэж хүсэж байгаа байхгүй юу. Тэгээд ТНБД гэсэн байх би энэ хүнээс нэг хүсэлт байна. Орчны бохирдлын асуудлыг би нэг 3 чиглэлээр боловсруулж хууль эрх зүйн орчин дээр зүгээр ажиллаж байгаа юм. Миний ажил жоохон удааширч байгаа. Тэгэхдээ би намрын чуулганд санаа байгаа боловсруулаад өргөн барья гэж бодож байгаа байхгүй юу.

Нэгдүгээрт энэ агаарын бохирдлын асуудал байгаа. Хөрсний бохирдол, дуу чимээний бохирдол. Дуу чимээний бохирдол бол хүнд ээ. Үнэхээр энэ бол ингээд хот суурин газарт аюултай байхгүй юу. Эргээд энэ төмөр зам дагасан бид хэд сүүлийн үед ийм мотоцикл унаж байгаа болон машинаа стандарт бус яндангаар тоноглоод ингээд шөнө 22 цагаас хойш дрифт хийгээд гудамжаар явж байхад ингээд арга хэмжээ энэ тэр авч байгаа ч юм алга гэх зэрэг юмнууд байгаа юм. Тэгэхдээ хамгийн эмзэглүүлж байгаа бөгөөд та бүгдийн өгч байгаа мэдээлэл байна шүү дээ хөрсний бохирдлын түвшнийг аймгаар нь авч үзвэл Төв аймаг, дүүргээр нь авчихвал Сонгино, Чингэлтэй, Баянзүрх гээд ингээд байж байна.

Тэгэхээр энэ асуудлууд байна. Энэ дээр ядаж танай дээр байгаа энэ судалгаануудыг нэгтгээд надад яг албан ёсоор мэдээлэл өгөөч гэж 1 дүгээрт би нэг ийм хүсэлтийг тавьж байна.

Хоёрдугаарт яах вэ зүгээр яг Улаанбаатар хоттойгоо л уялдуулж асууя. Энэ нэг 5 байршил дээр нэлээн хүнд металлын бохирдол ихтэй байна гэдэг дүгнэлтүүд гаргасан байна. Тэгэхээр энэ хүнд металлын хуучин энэ БЗД-ийн шар хад ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа. Олон жил энэ техникийн зах.

О.Номинчимэг: Сайнзориг гишүүн нэг минут.

П.Сайнзориг: Олон жил энэ техникийн захыг нүүлгэх асуудал ярьж байгаа. Хан-Уул, БГД-ийн завсарт байдаг энэ хуучнаар энэ Хан-Уулын нөгөө үйлдвэрчний район байна. Энийг Эмээлт аж үйлдвэрийн парк руу нүүлгэх гээд энэ тодорхой ийм төсөл хөтөлбөрүүд байгаа боловч энийг удааширч байгаа энэ асуудлууд байгаа. Тэгэхээр яах аргагүй энэ хүнд металл гэдэг юм уу энэнээс болж байгаа тэр иргэд хүүхэд залуучуудад үзүүлж байгаа эрүүл мэндийн асуудал бол нэлээн хүнд байгаа шүү дээ. Энэ дээр ЭМЯ ер нь ямар зөвлөмж өгч байгаа вэ? Энэ дээр ямар арга хэмжээ авахаар тооцоолж байгаа юм. Энэ бол ингээд нүдээ хараад өнгөрөөж

болохгүй. Маш их олон жилийн техникийн юу гэдэг юм үйл ажиллагаа явж байсан хэсэг дээр бохирдол байж байгаа.

Хоёрдугаарт энэ аялал жуулчлалын бүс нутгууд дээр анхнаасаа нүхэн жорлонгоо шууд хориглочих хэрэгтэй байна шүү дээ. Ерөөсөө ингээд бууруулна гээд байгаа мөртөө арга хэмжээ авахгүй. Энэ өөрөө эргээд татварын бодлогоор дэмжиж болно. Аялал жуулчлалын кемпүүдийг байгуулах үндсэн нэг шаардлагыг та нар ингээд хийчхэж чадахгүй ингээд л байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлууд дээр байж болох юм уу үгүй юу? Энэ дээр бас юу гэж бодож байна? Энэ оршуулгуудын асуудал байна. Ерөөсөө оршуулгын тухай хуулийг.

О.Номинчимэг: Байгаль орчны яам 8 номер.

Ш.Батбаяр: Сайнзориг гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт агаар, агаар хөрс, дуу чимээний бохирдолтой холбоотой нэгдсэн мэдээллийг яаралтай гаргаж танд хүргүүлье. Нийслэл хотод байгаа энэ хүнд металлын бохирдол бол таны хэлсэн санал нэг байна. Олон жилийн турш ажилласан автомашины засварын газрууд, хуучин ажиллаж байсан үйлдвэр ААН-үүдтэй холбоотой асуудал байгаа. Энэ дээр 1 дүгээрт хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх чиглэлээр биологийн нөхөн сэргээлт хийх 5 төслийг энэ жил бид эхлүүлж байгаа. Ирэх жилүүдэд төсвийг нэмээд явахаар байгаа.

Хоёрдугаарт одоо яг үйл ажиллагаа явуулж байгаа Нийслэл хотын хэмжээнд 700 гаруй авто засварын газрууд байгаа. Үүнээс өнгөрсөн 3, 4 дүгээр сард бид хяналт шалгалтыг төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж байгаа. 606 ААН дээр 2 мянга гаруй зөрчил дутагдлыг илрүүлсэн. Эдгээр зөрчил дутагдлыг залруулах албан даалгаврыг бид өгөөд байгаа. Мөн ААН-үүдийгээ цуглуулаад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байгаа. Хог хаягдлаа хэрхэн шийдвэрлэх вэ? Байгаль орчны үнэлгээгээ хэрхэн хийлгэх вэ? Хялбаршуулсан журмаар асуудлуудыг шийдэх нэгдсэн байдлаар асуудлыг шийдэх ажлыг хэрэгжүүлээд явж байгаа. Аялал жуулчлалын хувьд бол 2018 оны сайдын тушаалаар аялал жуулчлалын бүсүүд дээр нүхэн жорлонг бүрэн хориглосон байгаа.

Мөн усны сав газар болон тусгай хамгаалалттай газар нутаг дээр нүхэн жорлонг хориглож манай Байгаль орчны өөрчлөлтийн яам бол өөрөө манлайллаа гаргаад Сав газрын захиргаад, Тусгай хамгаалалтын газрын захиргаадынхаа нүхэн жорлонг бүрэн шийдвэрлэсэн байгаа. Тэгэхээр одоо тусгай хамгаалалттай газар нутаг болон сав газрууд аялал жуулчлалын кемпүүд дээр нүхэн жорлонг хориглосон хяналтууд тавиад шинээр байгуулагдаж байгаа ААН-үүдийнхээ байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээн дээр санал дүгнэлтээ тавиад шаардлагаа тавиад явж байгаа. Салбарын хяналтын байгууллагууд маань төлөвлөгөөт болон шалгалтуудаа тухай бүр нь хийгээд явж байгаа. Үүн дээр мөн орон нутгийн болон Аялал жуулчлалын яам бол давхар хяналтаа тавиад явж байгаа.

О.Номинчимэг: Дараагийн асуудал. Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулья.

П.Сайнзориг: Дээрээс нь энэ хөрсний бохирдлын хамгийн бас нэг суурь шалтгаан бол энэ оршуулгууд байхгүй юу. Одоо бид энэ газар төлөвлөлтийн асуудлыг ерөөсөө байсангүй. Хот төлөвлөлт газар төлөвлөлтийн асуудал маш хүнд байгаа. Улаанбаатар хотод энэ шинээр нэмж оршуулгын газар байгуулах газаргүй.

Төв аймгийн сумдууд руу явж байгаа. Энийг цаашдаа бид хэд хөрсөө бохирдуулахгүй байх чиглэлд яах вэ гэдэг зүйлийг эртнээс ярихгүй бол болохгүй байгаа юмаа.

Хоёрдугаарт, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргад би ганц зүйл хэлмээр байна. Хэдүүлээ ингээд суурь юмаа ойлгоогүй явж байна. Ер нь зүгээр аливаа үйл ажиллагааг хориглох үйл ажиллагааг зөвхөн хуулиар хийдэг юм. Байгаль орчны сайд байдаг юм уу хэн нэг албан тушаалтан хориглох үйл ажиллагааг гаргаад нэмэргүй. Хуулиар хориглоогүйгээс бусдыг нь ААНБ зөвшөөрдөг байхгүй юу. Тэгэхээр бид хэд ерөөсөө энэ үндсэн төрийн үйл ажиллагааны философийг ойлгоогүй хүмүүс байгаа учраас энэ бодлого шийдвэр чинь угаасаа хэрэгжихгүй байна. Ийм л харамсалтай зүйлийг би зүгээр хариултуудаас чинь хэлчихмээр байна.

Тэгээд бас үнэндээ хэлэхэд энэ хөрсний бохирдлыг чинь байгаль өөрөө цэвэрлээд байгаа. Бороо ороод л гол.

О.Номинчимэг: Оршуулгын газрын бодлого байгаа юу гэдэг асуудал байна. Оршуулгын газар түрүүн та хэдийн мэдээлэл ч гэсэн гэхдээ яах вэ мэдээллийг та бүхэн дараа Байнгын хороонд өгөхдөө их анхаарах хэрэгтэй. Тэр хүнд металлууд гарч байгаа энэ газрын зураг эд нар дээр харах юм бол сая сая Сайнзориг гишүүний хэлж байгаа. Яагаад энэ газрууд дээр хамгийн хүнд металлын бохирдол байна гэхээр 1 дүгээрт хог хаягдлын том нөгөө юунууд байгаа. Ландфиллийн газрууд байгаа. Оршуулгын газар байгаа. Дараагийнх нь хүнсний зах байгаа тийм үү? Чингэлтэй гэдэг бол тэнд оршуулгын газар юуны юу гарч байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн яг оршуулгын газар дээр бодлого болж барьж байгаа юм байна уу? Оршуулгын газраас үүдсэн хөрсний бохирдлыг хамгаалах тал дээр гээд Сайнзориг гишүүний асуултад хариулт хэн өгөх вэ? Хөрсний бохирдол.

Энэ мэдээллийг нь гаргаад өгчхөөч. Бид нар нийслэл хотод ямар оршуулгын газар байгаад байгаагаа мэдээд байна. Тэгтэл 21 аймгийн хэмжээнд энэ чинь яаж байна, бодлого нь яаж байна гэдэг юм ерөөсөө байхгүй. Хөрсний бохирдлын бас нэг гол нэг асуудал чинь энэ шүү дээ. Тэгээд их чухал асуудал байдаг. Бодлого байхгүй, дундаа ингээд хаягдчихдаг, орон нутаг л хариуцна гээд дээд талын бодлогын яам нь энэ дээр ямар нэгэн тоо дата мэдээлэл бодлого ч байхгүй байгаад асуудал байгаад байна. Тэр мэдээллүүдийг нь Сайнзориг гишүүнд гаргаад өгчих үү? Нийслэлээс тэр хэрэгжүүлж байгаа хөтөлбөртэй холбоотой дээр нь тэр түрүүн Сайнзориг гишүүний асуултад нь гарсан шүү дээ. Тэр нөгөө захууд байна. Тэгээд тэр Баянзүрхэд байгаа нөгөө нэг техникийн зах чинь тэр аккумуляторын тос мосоо шууд хөрс рүүгээ яагаад тэр нь их бохирдоод тэр хавьцаа миний санаж байгаагаар ЭМЯ ч билүү нэг гаднын төсөл хөтөлбөрөөр л бараг хүүхдүүдийн цусан дахь судалгаа эд нар хийхэд бүүр нөгөө байх ёстой хэмжээнээсээ хар тугалгана ч гэнэ үү маш их байна гээд аягүй сэтгэл эмзэглүүлэм тоон мэдээллүүд гарч байсан. Энэтэй холбоотой тэгээд цаашаа ямар арга хэмжээ хийх юм гэдэг дээр ингээд л зогсчоод байна л даа. Та хэдийн хийж байгаа арга хэмжээ бодож байгаа юм байна уу? ЭМЯ Нийслэл хоёр тэгвэл энэ дээр нэг хариулт өгөөдхөөч тэгэх үү? 2 номер юм уу, нэг номер юм уу? 2 номер нийслэл.

Ч.Гүнждагва: Оршуулгын газартай холбоотой ерөнхийдөө нийслэл дээр 1 20 орчим албан ёсны зөвшөөрөлтэй оршуулгын газар байдаг. 32 байршилд бол мянга гаруй га газрыг хамарч байдаг. Энэ дээр ерөнхийдөө нэлээн хүндрэлтэй асуудлууд

нэлээн байгаа. Жишээлбэл оршуулгын үйл ажиллагаа эрхлэх ААН-үүд дүүрэг болон нийслэлтэй гуравласан гэрээ байгуулаад үйл ажиллагаа явуулдаг. Тэгэхээр энэ нь яг тусгай зөвшөөрөлтэй байх ёстой юу, үгүй юу гэдгийг нэг талд нь гаргахгүй бол гэрээ байгуулагдсанаар тусгай зөвшөөрөл олгогдсонд тооцоод ингээд явуулах нэг иймэрхүү жишиг энэ гэрээгээр явж байгаа.

Тэгэхээр яг энэ оршуулгын үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь өөрөө тусгай зөвшөөрөлтэй байх эсэх асуудлыг нэн даруй яаралтай шийдэх ёстой. Нийслэлийн хэмжээнд ерөнхийдөө энэ оршуулгын үйл ажиллагаа эрхлэх ААН-ийг сонгон шалгаруулахтай холбоотойгоор.

О.Номинчимэг: 2 номер гүйцээж хариулъя.

Ч.Гүнждагва: Өөрсдийнхөө түвшинд яг нэг тендер зарлахтай холбоотойгоор байж байгаа нэг гол бодлого бол шатаах зуухтай байх гэсэн шаардлагыг ерөнхийдөө оруулж өгч байгаа. Тэгэхдээ энэ дээр яг зохицуулсан хууль болон хуулиар зохицуулсан тийм зохицуулалт байхгүй болохоор бас энэ шаардлага дээр оролцож байгаа зарим ААН-үүд гомдолтой байдаг. Ийм болохоор энэ дээр бас Чинзориг гишүүнтэй нийслэлийн зүгээс нэлээн хамтарч ажиллаж холбогдох мэдээллүүдийг хүргүүлж ажиллахад бэлэн байна.

О.Номинчимэг: ЭМЯ тэн дээр та бүхэн сая хөрсний бохирдлоос үүдсэн савханцар гээд л зөвхөн ярьсан. Тэгэхээр хүнд металл энэ техник янз бүрийн тосноос үүдсэн эрүүл мэндэд нөлөөлж байгаа нөлөөллийн мэдээ дата юу хийх ёстой зөвлөмж арга хэмжээ төлөвлөсөн юм байна уу? Энэ дээр мэдээлэл өгнө үү? 5 номер.

Н.Эрдэнэбаяр: Сайнзориг гишүүний асуултад нэмэлтээр тодруулъя аа. Энэ Эрүүл мэндийн яамнаас бид нар яах вэ энэ салбарын хяналтын чиг үүрэг Эрүүл мэндийн яаманд ирсэн байж байгаа. 2023-2025 онд бид нар ер нь энэ хөрсний дээжид хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслээд аймаг, дүүргийн ЗДТГ-т 38 дүгнэлт хөрсний бохирдлын түвшний нөхцөл байдлын мэдээлэл зөвлөмжийг 12 албан бичгээр яг хүргүүлсэн байж байгаа. Гэхдээ энэ дээр бид нар яг авч байгаа арга хэмжээний талаарх тайлангуудыг нэгтгэж танд нэмэлтээр хүргүүлэх боломжтой. Ер нь зүгээр олон улсад барьж байгаа нэг чиг баримт л байгаад байгаа юм. Хүний эрүүл мэндийг бид нар ярихын тулд зөвхөн бид нар ярихын тулд зөвхөн одоо дан эрүүл мэнд гэхээс илүүтэй энэ нөгөө нэг эрүүл мэнд гэдэг үзэл баримтлалын хүрээн дээр энэ дээр ялангуяа энэ үндэсний энэ стратегийг боловсруулж хэрэгжүүлдэг. 2 удаагийн стратеги хэрэгжиж дуусаж байгаа. Шинэ стратегийг хэрэгжүүлэхээр байгаа. Энэ дээр ЭМЯ, Хүнс, хөдөө аж ахуйн яам тэгээд байгаль орчны Уур амьсгалын өөрчлөлтийн яам бас энэ жилээс нэмэгдэж байгаа юм. Ингээд ер нь бид нар цогцоороо харж энэ төлөвлөлтүүдээ.

О.Номинчимэг: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр 2 гишүүнээр үг хэлэх гишүүнийг тасаллаа. Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

О.Саранчулуун: Хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах нэгдсэн төлөвлөгөөгөө бид нар яаралтай эргэн харах хэрэгтэй байгаа. Тэгээд ер нь энэ хөрсний бохирдол дээр хамгийн том нөлөөлж байгаа зүйл бол энэ ил задгай жорлон, бохир ус байгаа. Нөгөө талдаа хог хаягдлын буруу менежмент байгаа. Бид нар нэг энэ асуудлыг ингээд ярихлаар заавал нэг үндэсний хороо байгуулах ёстой

байсан гээд байх юм. Энэ чинь угаасаа ЗГ-ын төлөвлөгөөндөө орчихсон хуульдаа байгаа зүйл байгаа. ЭМЯ бүх яамдууд Засаг дарга нартай он гараад нэг сар гэрээ хийдэг байгаа. Тэр гэрээн дотроо орчны эрүүл мэндийн асуудал дээр үүрэг хүлээсэн байгаа Засаг дарга нар. Үүргээ хүлээгээд биелүүлж байгаа хүмүүст нь ямар урамшуулал байдаг юм. Үүргээ биелүүлэхгүй байгаа хүмүүст нь ямар санхүү байдгийг бид нар эргэж ярих хэрэгтэй юм байна лээ. Тэгэхгүй бол ингээд нэг гэрээ хийсэн ёсолсон болоод орхичихдог. Энэ асуудал бол нийгмийн эрүүл мэндийн асуудал. Дандаа ингэж орхигддог. Эрүүл мэндийн яамнаас тоо баримтыг нь гаргаад л байгаа. Тэнд ч хүн өвдөөд байна энд ч халдвар байгаад байна гээд яриад байдаг. Гэтэл эргээд тэрнийхээ мөрөөр нөлөөллийн ажил хийх гэхээр салбар дундын асуудал байна гээд байдаг. Гэхдээ энэ дээрээ жоохон гэрээгээ биелүүлэхгүй байгаа, нийгмийн эрүүл мэндийн энэ хуулийн дагуу 10.1-ийн заалтаа хэрэгжүүлэхгүй байгаа Засаг дарга нарыг зарлах хэрэгтэй байна. Хэдүүлээ энэ жил эхлээд 100 жилээ нүхэн жорлонгүй тэмдэглээ ээ улс орноороо.

Олон улсын эвент хийх гэж байна шүү дээ манайх Коп гээд уур амьсгалын асуудлаар. Тэгээд энэ дээрээ бид нар ингээд нүхэн жорлонтой бензин колонкууд, нүхэн жорлонтой аялал жуулчлалын газруудтайгаа байгаад байх юм. Энийгээ жоохон тоог нь цөөлөх хэрэгтэй байгаа. Хийснийг нь урамшуулаад хийгээгүйг нь ажлаас нь хариуцлага тооцдог юмыг ярих хэрэгтэй болчихоод байгаа байхгүй юу. Бид нар ингээд 100 жил ойн баяр наадмынхаа үеэр аягүй супер супер ийм сумын хаалга, аймгийн хаалга, бөх, морины болон өчнөөн олон хөшөөнд хэдэн зуун сая төгрөг зарцуулдаг мөртөө тэрнийхээ оронд нэг ч жишиг ариун цэврийн байгууламж барьдаг ийм л улс болмоор байна. Яг ний нуугүй хэлэхэд энэ чинь нийгмийн эрүүл мэнд байхгүй юу. Тэгээд энд амьдарч байгаа хүний эрүүл мэндийн асуудлыг яриад байна.

Хоёр дахь том асуудал бол хог хаягдлын менежмент байгаа. Хүүхдүүд сургууль дээр бид нар хог ангилахын тухай өчнөөн төрийн бус байгууллагууд санаачилгууд хувь хүн, бор зүрхээрээ тэнд хогоо ангилах тухай заагаад л яриад байдаг. Хогийн машин ирээд нийлүүлээд аваад явахаар чинь тэнд ямар ялгаа байна аа. Тэгэхээр чинь хүмүүс сөх-ууд болон тэр хотхонуудын хогийн сав тусдаа байгаад ч нэмэр алга байна шүү дээ. Нийлүүлээд аваад явчхаж байгаа юм чинь. Тэгэхээр энэ дээр бид нар нэг арга хэмжээ авахгүй бол болохгүй нь ээ. Шинээр ашиглалтад орж байгаа үнэтэй, үнэтэй хотхонууд байрууд ер нь хог хаягдлын менежмент дээр яг яадаг вэ? Ямар нэгэн манлайлал үзүүлсэн ийм зүйлүүдийг хийх хэрэгтэй байгаад байна. Ер нь энэ дээр бид нар хог хаягдал чинь өөрөө хүний зан үйл байгаад байгаа, ариун цэврийн хэрэглээ чинь өөрөө хүний зан үйл байгаад байгаа. Тэгэхээр яадаг юм энэ шийдвэр гаргахгүй байгаа дарга нар нь өөрсдөө нүхэн жорлон энэ тэрд бие засдаггүй болохоор шийддэггүй юм уу, яадаг юм. Шинээр төв суурин газар суурьшиж байгаа иргэдэд энэ асуудлыг мэдээлэл өг гэхээр хэсгийн ахлагч нарын үүрэг гэдэг хариулт яриад байх юм. Ийм байж болохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр аймаг, дүүрэг, сум, бүх Засаг дарга нар шинээр суурьшиж байгаа хүмүүст иргэдэд тэр ариун цэвэр хөрс хог хаягдлын асуудал дээр бодитой ажил гаргая. Энэ дээр санаачилга гаргамаар байна гэдгийг би бүүр энэ дээр анхааруулмаар байна.

Дээрээс нь энэ дээр ямар ямар төлөвлөгөө байна. Энийгээ танилцуулмаар байна. Гадаадаас 1 дор ингээд 5, 10 тэргэнцэртэй хүн ирэхэд л манайд орох бензин колонк аялал жуулчлалын газар байхгүй болчихоод байна шүү дээ. Бид нар нэгд жорлонгийн асуудал ярьж байгаа.

Хоёрт хүртээмж яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр хүртээмжээ ч гэсэн сайжруулаад нэгмөсөн хамтад нь ингэж шийдэхгүй бол цаана чинь аялал жуулчлалаар Монголд ирж байгаа хүмүүс ингээд Чингисийн зураг энэ тэрийг тавьчихсан. Тэгээд доор нь нөгөө модон жорлонд бие зассанаа яриад рийл хийгээд шившиг болж байна шүү дээ. Би л лав ичиж байна аа. Тэгэхээр энэ дээр жоохон санаачилгатай ажилламаар. Ганцхан Байгаль орчны яам гэхгүй ЭМЯ бүх засаг дарга нар энэ дээр энэ зун хэдүүлээ жоохон цөөхөн жорлонтой баярламаар байна. Ийм л үгийг хэлмээр байна. Тэгээд энэ дээр хамтран ажиллах хэрэгтэй. Яагаад гэвэл нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого байхгүй юу энэ чинь. Ганцхан одоо нэг баяр ёслолын хүрээнд яригдах ёстой зүйл биш байгаад байгаа байхгүй юу.

О.Номинчимэг: Баярлалаа Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Юун түрүүнд Өргөдлийн байнгын хороондоо ийм чухал асуудлыг хэлэлцэж байгаад баярлаж байгаа юм. Би нөгөө БОХХАА-н байнгын хороо ийм асуудлуудыг ярих болов уу гэхээр ярихгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид хэд хэт их улс төржиж популизм ярьж байгаа гэж яг хүний суурь эрхийн асуудал ярьсан ийм бодит амьдралдаа тулсан юмнуудыг ерөөсөө гарц шийдлийг нь ярихгүй байгаа юмаа. Тэгээд ер нь зүгээр яах вэ энэ хөрсний бохирдлын асуудлыг байгаль өөрөө цэвэрлэж байна. Бид хэд тэгсхийгээд л дуугүй өнгөрч байгаа. Тэгэхдээ байгаль цэвэрлэхдээ ерөнхийдөө их хэмжээний эрсдэлүүдийг үүсгэж байна аа. Энэ зуслангийн бүсүүд дээрх энэ Сэлбэ голын цаашдаа менежментийг зөв хийхгүй, далан тохируулгыг хийхгүй байх юм бол ер нь зүгээр зуслангийн бүсийн болоод ойролцоох амнууд дахь гэр хорооллын нүхэн жорлон хальж урсаж орж ирээд хотын төвөөрөө дамжаад тэгээд цаашдаа Туул руу цутгаж байгаа. Яг энэ дээрээс ярих юм бол хүн малын гоц халдварт өвчин гэдэг шиг хүний гоц халдварт өвчин яагаад улсаараа нийслэлийн Улаанбаатар хот нь карантинд орох магадлал маш өндөр байгаа. Тэгэхээр энэ өөрөө тоглоом биш болчихсон асуудал байгаа юм аа.

Тэгэхээр энэ дээр миний асуудал юу вэ гэхээрээ хэдүүлээ тэр хөрөнгө мөнгө хандив мөнгөөр босгоод ч юм уу ингээд шийдээд явах энэ хувилбараас ер нь татгалзмаар байна аа. Одоо ингээд л Эрдэнэт үйлдвэрийг нийгмийн хариуцлагын хүрээнд баахан хүүхдүүдийн 0 цэвэрлэ гээд ингээд ийм зохисгүй л юм хийлгээд байгаа байхгүй юу нэг талдаа. Тэгэхээр би юу хэлэх гэж байна гэхээр энэ газрын менежмент буюу газрын төлбөртэй энэ менежмент дээр бид хэд уялдуулмаар байна аа. Яг энэ зарим газар эзэмшиж байгаа ялангуяа иргэдэд өмчлүүлсэн эзэмшүүлж байгаа энэ газрын төлбөрүүдийг шууд чөлөөлчхөж байгаа юм. Нүхэн жорлонгоосоо ядаж ангижирсан чөлөөлдөг баймаар байгаа байхгүй юу.

Эсвэл хашаандаа ядаж нэг 2, 3 бут сөөг мод тарьчихсан байвал чөлөөлдөг болмоор байна. Бүх зүйлүүдийг бид нар иргэддээ үнэгүй өгдөг ч юм уу нэг ийм байдлаар явж байгаа юм. Наадах чинь ингээд хүмүүсийн баас шээсийг төр засаг цэвэрлэж өгөх өөрөө үүрэг хүлээчхэж байгаа байхгүй юу. Сүүлдээ ингээд нэг хүний ч юм уу нэг өрхийн асуудал биш болоод наадах чинь ингээд гэр хорооллын буюу нийт суурин газруудын асуудал болчхож байгаа учраас төр оролцохоос өөр арга байхгүй. Тэгээд ийм зүйлүүд их байна аа.

Тэгэхээр энэ дээр би газрын менежмент буюу газрын төлбөрийн асуудлын энэ менежментийг зөв хуваарилж байж энэ хөрсний бохирдол үүсэж байгаа нүхэн жорлон татварын бодлогоор явах ёстой. Зарим тохиолдол дээр захиргаадалт

хэрэглэнэ. Ялангуяа тэр тусгай хамгаалалттай газар нутаг, аялал жуулчлалын кемпүүд дээр 2018 оноос хойш нүхэн жорлон байгуулахыг хориглочихсон гээд нүүр бардам хэлээд байгаа ч энэ хэрэгжээгүй шүү дээ. Энэ Тэрэлж гараад л үз л дээ бүгд л нүхэн жорлонтой л байна шүү дээ. Яаж ичихгүй ингээд төрийн нарийн минь ийм мэдээлэл хэлээд сууж байна аа. Би өмнөөс чинь жоохон ичээд байна.

Тэгээд хууль зүйн болоод төрийн бодлогын шийдвэр гаргалт чинь юу билээ. Хуулиараа хориглохгүй бол бусад зүйлүүд чинь ингээд нэг сайд нэг их ийм улс төрийн популизм хийж чөлөөлсөн энэ тэр гээд ийм наад байгаль орчны салбар чинь ер нь үе үеийн нэг ийм сайдын дамжаа шиг болчихоод байгаа шүү. Тэгээд хүмүүсүүд нь ийм ултай суурьтай бодлогын асуудал ерөөсөө ярьдаггүй. Баахан төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. Тэгээд энэ байгаль орчны хуулиудыг цогц уялдаатай хэрэгжүүлэхийн оронд задалж 1, 1-ээр нь аваачиж бүлэг бүлгээр нь бие даасан хууль болгоод ямар ч уялдаагүй зах замбараагүй юм болгож байгаа юм. Би өөрөө энэ салбарт ажиллаж байсан. Энэ юмыг ингэж болохгүй шүү гэдгийг би бараг энэ салбараас чинь ажлын гараагаа эхэлж байсан учраас хэлж байсан. Тэгээд одоо энэ хүртэл хандлага нь арилахгүй байгаа байхгүй юу. Ерөөсөө ингээд л донор байгууллагуудыг яагаад л өө тийм ч хууль хийчихье, ийм ч хууль хийчихье гээд ямар ч амьдралгүй хуулиуд.

Тийм учраас энэ асуудлууд чинь үүсэж байна аа. Тэгээд орон нутгийг бас чиг үүрэг өгч байгаа бол энийг нь процесстой болгож өгөх ёстой хүлээх, хариуцлагатай болгож өгөх ёстой. Ажлын уялдаатай болгож өгөх ёстой байхгүй юу? Тэгээд ямар ч байсан энэ орчны бохирдлын асуудал дээр хэдүүлээ нэг энэ хуультай болох ёстой. Эсвэл байгаль хамгаалах хууль дээрээ бид нар энэ чиглэлийн нэг бүлгийг оруулж өгөх ёстой. Номинчимэг гишүүн, дарга бололцоотой эсвэл танай Байнгын хорооныхтой хамтардаг юм уу яадаг юм би бол нэг 3 чиглэлээр нэг драфтыг жоохон босгох гээд оролдоод яваад байгаа. Тэгэхдээ мэргэжлийн бус учраас жоохон хүндрэлтэй зүйлүүд байна.

О.Номинчимэг: Баярлалаа. Тийм энэ яг манай Өргөдлийн байнгын хороон дээр бид нар энэ хуулийн хэрэгжилт ерөөсөө л ингээд салбар дундын уялдаа холбоо байхгүй бие биедээ найдаад хаячихдаг. Тоо дата нь нэгтгэгдээгүй учраас хэн нь юугаа хийхээ мэдэхгүй ийм болчихсон асуудлууд байгаа. Тэгээд энэ нүхэн жорлон, хөрсний бохирдлын асуудал ч гэсэн бид нар ингээд л ярьдаг боловч яг тэгээд хэн нь юу хий хийж байна гээд ингэхээр ийм салангид нэгдсэн юм байхгүй байгаад байгаа. Тэгэхээр хууль эрх зүйн орчин үнэхээр энэ дээр засах бол бид нар ч гэсэн хамтарч ажиллая. Манай яамдууд ч гэсэн энэ мэдээллүүдээ нэгтгээд өгөх хэрэгтэй байна. Анхаарах хэрэгтэй байна.

Саранчулуун гишүүний хэлж байгаа тэр үнэхээр 100 жилээ тэмдэглэж байгаа бол бид нар ядаж энийгээ нүхэн жорлонгоо байхгүй болгодог ийм юм хийе. Тэгээд Ундрам гишүүний тэр хэлж байгаа тэр албан байгууллагууд бол шаардлагыг нь өг. Сайнзориг гишүүний хэлж байгаа тэр зуслан эд нар нөгөө нэг нөгөө нэг газраас нь чөлөөлж байна гээд л яриад байгаа шүү дээ. Тэгвэл тэрнийх нь нэг шаардлага болгоё л доо. Нүхэн жорлонгүй байя. Хөрсний бохирдлоос сэргийлсэн арга хэмжээ авъя тэгж байж энэ хөнгөлөлт хөтөлбөртөө ордог больё гэдэг ийм хөшүүргүүдийг бид нар хийх ёстой. Тэрнээс бүгдээрэн дээр нь төсөв тавиад бүгдээрэнг нь өөрчилнө гэвэл ёстой 800 жорлонг 5 жилийн хугацаанд 160 тэрбумд зарсан гэдэг шиг л хэзээ ч биелэхгүй 500 гаран мянган нүхэн жорлонгийн асуудал барьж байгаа учраас ийм ийм олон хөшүүргүүдийг хиймээр байна.

Та бүхэн ч гэсэн уялдаа холбоотой мэдээллүүдээ гаргаж өгмөөр байна. Бид ч гэсэн энд хүмүүсийн манай Өргөдлийн байнгын хороон дээр ерөөсөө ирж байгаа 3 гол асуудал энэ шүү дээ. Нэг нь бол эдийн засгийн холбоотой асуудал байгаа. Татвар, нийгмийн даатгал. 2 дахь нь бол шударга ёсны асуудал байгаа. Хүний эрх зөрчигдөж байгаа шударга ёс хангагдахгүй байгаа.

Гурав дахь нь ерөөсөө л хүний амьдрах орчинтой холбоотой асуудал байгаа шүү дээ. Тэгээд энэ хүний амьдрах орчинтой холбоотой асуудлын нэг яалт ч үгүй нүхэн жорлонг ийм тав тухгүй байдал эндээс үүсэж байгаа бохирдол нийгмийн эрүүл мэндийн асуудал байгаад байгаа болохоор энэ асуудлыг бид нар бодлогын төвд анхааралд оруулж шийдлийг олон талын ёстой нөгөө Засгийн газрын цогц төлөвлөгөө гэдгээ ч өөрсдөө мэдэхгүй байгаа бол Улсын Их Хурал энэ дээр нь цогц төлөвлөгөө чинь ийм байх нь гэдгийг та бүхэнтэй хамтраад хийхээс өөр аргагүй асуудлыг нь шийдэхээс өөр аргагүй байгаа гэдгийг хэлмээр байна.

Манай яам тамгын газрынхан энэ дээр бас мэдээллээ нэгтгэж түргэн шуурхай хамтарч ажиллана гэдэгт итгэж байна. Бид хэрвээ түрүүн хүүхдийн хооллолтой холбоотой асуудлаар ийм шийдэл гаргая гэж байгаа шиг энэ жорлон нүхэн жорлон, хөрсний бохирдолтой холбоотой асуудал дээр ч гэсэн чиглэл өгөх ийм ажлуудыг хийж болно. Тэгээд шаардлагатай гэвэл манай Байнгын хорооны гишүүд ч гэсэн санаачлаад ийшээгээ чиглэсэн юмнуудыг хийе гэж бодож байна гэдгийг эцэст нь хэлмээр байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Төв суурин газар, аймаг, нийслэлийн хөрсний бохирдол, нүхэн жорлон, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайд болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг хэлэлцүүлж дууслаа.

Ингээд Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

13.00 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА